

“Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн тайлан

Товчилсон үгсийн жагсаалт

Оршил

Нэг. Үндэслэл

Хоёр. Тайлангийн хураангуй

Гурав. Мониторингийн арга зүй, аргачлал

- 3.1 Мониторингийн арга зүй
- 3.2 Мониторингийн аргачлал

Дөрөв. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийн хураангуйлсан үр дүн

Тав. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт, орчин нөхцөл байдал

5.1 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын идэвх, санаачлага

- 5.1.1 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн талаар төрийн байгууллагууд хэр мэдээлэлтэй байна вэ?
- 5.1.2 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар төрийн байгууллагууд хэр анхаарч байна вэ?
- 5.1.3 Төрийн байгууллагуудад Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх бүтэц бий юү?
- 5.1.4 Төрийн байгууллагууд Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд ямар арга хэмжээ авч байна вэ?

5.2 Төрийн байгууллагууд дахь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжүүлэх дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт

- 5.2.1 Төрийн байгууллагуудын мэдээллийг хүртээмжтэй байлгах дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт
- 5.2.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй байгах дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт
- 5.2.3 Төрийн байгууллага үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангах дотоод нөөц боломж ба түүний хэрэгжилт

Зургаа. Иргэдээс санал, гомдол хүлээн авах 19-77 утасны мэдээлэл

Долоо. Дүгнэлт, зөвлөмж

Найм. Ашигласан материалын жагсаалт

Ес. Хавсралт

- 9.1 Авлигатай тэмцэх газрын зөвлөмж
- 9.2 Судалгаанд хамрагдсан байгууллагын нэрс
- 9.3 Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын чиг үүрэг

Товчилсон үгсийн жагсаалт

АМГТХЭГ - Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газар
АТГ - Авлигатай Тэмцэх Газар
БГД - Баянгол дүүрэг
БЗД - Баянзүрх дүүрэг
ГССЗҮТ – Гэмтэл согог сэргээн засварлах үндэсний төв
НДХ – Нийгмийн даатгалын хэлтэс
НОБГ – Нийслэлийн онцгой байдлын газар
НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага
СБД - Сүхбаатар дүүрэг
СХД - Сонгино хайрхан дүүрэг
ТББ - Төрийн бус байгууллага
ТӨХ – Төрийн өмчийн хороо
ТХ – Татварын хэлтэс
ХУД - Хан–Уул дүүрэг
УИХ - Улсын Их Хурал
УК-1/2/3-р эмнэлэг - Улсын клиникийн нэгдүгээр/хоёрдугаар/гуравдугаар эмнэлэг
ЧД - Чингэлтэй дүүрэг
ШБӨХЗГ – Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар
ШШБА – Шүүхийн шийдвэр биелүүлэх алба

Оршил

“Глоб Интернэшнл” ТББ-аас 2007 оны 7 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарыг дуустал хагас жилийн хугацаанд “Төрийн байгууллагын нээлттэй, ил тод байдлын мониторинг” төслийг Авлигатай тэмцэх газрын захиалга (АТГ), Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүллээ.

АТГ нь “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах” чиг үүргийнхээ хүрээнд “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах” талаар гурван бүлэг, 18 зүйл бүхий зөвлөмжийг (хавсралтаас үзнэ үү) 2007 оны 4 дүгээр сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн юм. Уг зөвлөмжийн дагуу төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодитой мэдээлэлтэй болох, энхүү мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгаа, хэрэв хэрэгжихгүй байгаа бол үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн санал бүхий ерөнхий зөвлөмж боловсруулах зорилготой байлаа.

Төслийн хүрээнд 21 хүний бүрэлдэхүүнтэй баг төрийн байгууллагуудаас хоёр шаттайгаар мониторингийн мэдээлэл цуглуулах ажил зохион байгуулсан. Нэгдүгээр шатны мэдээллийг 2007 оны 8 дугаар сарын 5-наас 10-ны өдрүүдэд бүрдүүлэн үр дүнг 9 дүгээр сарын 14-нд хэвлэлийн бага хурал хийж, олон нийтэд танилцуулсан. Хоёрдугаар дугаар шатны мэдээллийг 2007 оны 10 дугаар сарын 8-наас 19-ний өдрүүдэд бүрдүүлж, үр дүн нь 11 дүгээр сарын 19-нд бэлэн болсон юм. Мониторингийн хугацаанд 1977 дугаарын шууд утас ажиллуулж, төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтны зөрчилтэй үйл ажиллагааны тухай иргэдийн санал, гомдлыг хүлээн авч, АТГ-т долоо хоногт хоёр удаа хүргүүлж байлаа. АТГ-аас холбогдох мэдээллийн дагуу зөрчил бүхий төрийн байгууллагын удирдлагад үйл ажиллагаагаа засч залруулах талаар шаардлага хүргүүлж ажилласан. Шууд утсанд нийт 330 иргэн хандсан бөгөөд тэдний санал, гомдлыг судлан үзэж, тайланг сар бүрээр мөн нэгдүгээр шатны мониторингийн үр дүнг АТГ, “Глоб Интернэшнл” ТББ-ын вэб сайтаар олон нийтэд тус тус танилцуулсан.

Мониторингийн судалгаанд төрийн 200 байгууллагын 200 ажилтан, 200 албан тушаалтан, 780 үйлчлүүлэгч иргэнийг хамруулахаас 197 байгууллагын 189 ажилтан, 185 албан тушаалтан, 749 иргэн тус тус оролцсон болно.

Мониторингийн судалгааны арга зүйг 2007 оны 7 дугаар сард багтаан боловсруулж, тандалт, сурвалжилгын анкетын асуулга бүрээр сорил хийн, эцэслэн боловсруулсан юм. Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах дадлага, чадвар эзэмшүүлэх сургалтыг 2007 оны 8 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан.

Та бүхэнд хоёр шатны мониторингийн нэгдсэн тайланг толилуулж байна.

Энэ тайлан нь оршил; үндэслэл; төслийн хураангуй; АТГ-ийн зөвлөмжийн хэрэгжилтийн хураангуй; АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилт, орчин нөхцөл; иргэдээс санал, гомдол хүлээн авах 1977 шууд утасны мэдээлэл; дүгнэлт, зөвлөмж; зэрэг есөн дэд хэсгээс бүрдэнэ.

Мониторингид хамрагдсан төрийн байгууллагууд, иргэд болон төслийн багийн гишүүддээ талархал илэрхийлье.

Цаашид төрийн байгууллагууд судалгааны мэдээлэл, үр дүнг ашиглан, үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод болгох чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдэд мэдээллээр үйлчлэх үүргээ сайжруулан ажиллана гэдэгт найдаж байна.

Нэг. Мониторингийн үндэслэл

Ард түмэнд нээлттэй мэдээллээр үйлчлэх нь төрийн ил тод байдлын үндсэн шалгуурын нэг юм. Иргэд мэдээлэлтэй байх эрхийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” хэмээн заасан байдаг.

Түүнчлэн төрийн албанд баримтлах зарчмыг төрийн албаны тухай хуулийн 4.2.2-т “ил тод байх”, 4.2.3-т “ард түмэнд үйлчлэх” гэж баталгаажуулсан билээ.

“Глоб Интернэшнл” ТББ-аас Лондон хотноо төвтэй Олон улсын 19-р зүйл байгууллагатай (ARTICLE 19) хамтран бэлтгэсэн “Монгол Улс шилжилтийн үед. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ” судалгааны тайланд “Монгол улсын төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй байна” хэмээн дүгнэсэн.

Мөн сүүлийн үед манайд хийгдсэн олон улсын, дотоодын бодлогын институцийн бүхий л түвшний судалгаа, мониторингоор авлига, хээл хахууль нь монголын нийгмийн хөгжлийг чөдөрлөж буй том асуудал болоод байгаа нь нотлогдсон билээ.

Өнөөдрийн байдлаар Монголд 360 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас мэдээлэл нээлттэй, ил тод байх зарчим, хэм хэмжээг зохицуулсан 120 гаруй хууль байна.

УИХ 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Авлигын эсрэг НҮБ-ын конвенц”-ийг соёрхон баталж, 2006 оны 7 дугаар сарын 6-нд төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр нэлээд шинэлэг зохицуулалт хийсэн нь “Авлигын эсрэг хууль”-ийг баталсан. Энэ нь Монголд авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх бие даасан институцийг бий болгосон өндөр ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

АТГ байгуулагдсанаасаа хойш авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнийг бий болгож буй нөхцөл, шалтгаан болон өдөөгч хүчин зүйлсийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагын нэг нь “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах талаар” гурван бүлэг 18 зүйл бүхий зөвлөмж билээ.

Төрийн байгууллагуудаас уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд гаргаж буй идэвх санаачлага, зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг бодитойгоор тооцсон хөндлөнгийн байгууллагын судалгааны суурь мэдээлэл дутагдалтай байсан нь тус мониторинги хийх гол хэрэгцээ, шаардлага болсон юм.

Хоёр. Тайлангийн хураангуй

Ард түмэнд нээлттэй мэдээллээр үйлчлэх нь төрийн ил тод байдлын үндсэн шалгуурын нэг юм. Иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан байдаг.

“Глоб Интернэшнл” ТББ-аас Лондон хотноо төвтэй Олон улсын 19-р зүйл байгууллагатай (ARTICLE 19) хамтран бэлтгэсэн “Монгол Улс шилжилтийн үед. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ” судалгааны тайланд “Монгол улсын төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй байна” хэмээн дүгнэсэн.

2006 оны 7 дугаар сарын 6-нд “Авлигын эсрэг хууль”-ийг баталж, тус хуульд заасанчлан “Авлигатай Тэмцэх Газар”-ыг байгуулсан юм.

АТГ нь авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнийг бий болгож буй нөхцөл, шалтгаан болон өдөөгч хүчин зүйлсийг арилгах арга хэмжээ аван хэрэгжүүлж байна. Үүний нэг нь “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах талаар” гурван бүлэг 18 зүйл бүхий зөвлөмжийг боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ.

Төрийн байгууллагуудаас уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд гаргаж буй идэвх санаачлага, зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл зэргийг бодитойгоор тооцсон хөндлөнгийн байгууллагын судалгааны суурь мэдээлэл дутагдалтай байсан нь тус мониторингийг хийх гол хэрэгцээ, шаардлага болсон юм.

АТГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодитой мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжихгүй байгаа шалтгаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж боловсруулах зорилгоор мониторингийн судалгааг 2007 оны 7 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Зорилгодоо хүрэх үүднээс “АТГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг тогтоох, АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын идэвх, оролцоог үнэлэх, Төрийн байгууллагууд дахь АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх дотоод нөөц, боломжийг тодорхойлох, АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж гаргах” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно.

Мониторингийн судалгааны баг нь анализийн ба тандах судалгааны баг гэсэн бүтцээр ажилласан. Арга зүй, анализийн баг нь зөвлөх, хоёр судлаач; тандах судалгааны баг нь төслийн судалгааны мэдээлэл цуглуулах 14 мониторингч, мэдээлэл оруулах, нээлттэй асуулгыг кодлох үүрэгтэй хоёр мониторингч, шууд утсаар мэдээлэл хүлээн авах нэг мониторингч, төслийн зохицуулагч гэсэн нийт 21 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

Мониторингийг хоёр үе шаттайгаар хийж, нэгдүгээр шатны мэдээллийг ажиглалт, сурвалжилгын судалгаагаар бүрдүүлж; хоёрдугаар шатны мониторингийн суурь мэдээлэл болгон ашигласан. Хоёрдугаар шатны мониторингийн мэдээллийг мөн ажиглалт, сурвалжилгын анкет болон бичиг баримтын шинжилгээний аргаар бүрдүүлсэн. Түүнчлэн төслийн хугацаанд 1977 дугаартай шууд утсаар үйл ажиллагаандаа зөрчил гаргасан төрийн байгууллагын талаар нийт 340 иргэнээс мэдээлэл авч, АТГ-т хүргэж байв.

Судалгаанд Улаанбаатар хотод байршилтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий улс, нийслэл болон дүүргийн хэмжээний төрийн 200 байгууллага, 200 ажилтан, 200 албан тушаалтан, 780 үйлчлүүлэгч иргэнийг хамруулахаас 197 байгууллага, 185 ажилтан, 189 албан тушаалтан, 749 иргэн оролцов.

Нийт мониторингийн судалгааны үр дүнгээс харахад;

АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын идэвх санаачлага хангалтгүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын 41 хувь нь зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бол, 12 хувь нь зөвлөмжийг судлах шатандаа, 34 хувь нь зөвхөн тойм мэдээлэл авсан төдий байгаа бол 13 хувь нь зөвлөмжийн талаар мэдээлэлгүй байсан.

Харин АТГ нь сүүлийн саруудад үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хяналтаа сайжруулсантай холбоотойгоор төрийн байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл явцын идэвх сайжрах хандлага ажиглагдсан нь нааштай үзүүлэлт болж байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын талаас илүүд нь иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар санал, гомдол ирүүлэхэд хэдийгээр холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм байдаг ч гаргасан зөрчлийг арилгах тал дээр сул ажиллаж байна. Мониторингийн судалгаа хийх явцад үйлчлүүлж байсан нийт 430 иргэний 33 хувь нь тухайн байгууллагадаа гомдол гаргаж байжээ. Тэдний зөвхөн 13 хувь нь л асуудлаа шуурхай шийдвэрлүүлж чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарч байсан, 52 хувь нь огт шийдвэрлүүлж чадаагүй байна.

Хэдийгээр төрийн байгууллагуудад иргэдээс санал, гомдол хүлээн авах нөөц боломж байгаа ч санал, гомдлыг хүлээн авч, барагдуулах механизм хангалтгүй ажиллаж байна. Үүнд нэг талаас санал, гомдол хүлээн авах арга хэлбэрээ олон нийтэд танилцуулаагүй, иргэд энэ талаар мэдээлэлгүй байдаг. Нөгөөтэйгүүр төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл үлэмж алдарсан байдал судалгаагаар ажиглагдсан бөгөөд энэ нь нөлөөлж байна гэж үзэж болно.

Иймээс дээрх байдлыг үндэслэн бид чиглэл тус бүрээр дэлгэрэнгүй зөвлөмж гаргасныг та бүхэн уг тайлангийн 50 дугаар хуудаснаас үзэж болно.

Зөвлөмжийг тоймловол:

АТГ нь төрийн байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтэд тавих хяналтаа сайжруулах шаардлагатай байна.

Мөн төрийн байгууллагуудад уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах суурь нөөц боломж хангалттай бүрдсэн байна гэж үзэж байгаа бөгөөд гагцхүү энэ механизмыг ажиллуулах шаардлага АТГ-т тавигдаж байгааг анхаарах нь зүйтэй.

Гурав. Мониторингийн арга зүй, аргачлал

3.1 Мониторингийн арга зүй

3.1.1 Мониторингийн зорилго

АТГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодитой мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны гол зорилго оршино.

3.1.2 Мониторингийн зорилт

Энэ зорилгодоо хүрэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

- АТГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг тогтоох
- АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын идэвх, оролцоог үнэлэх
- Төрийн байгууллагууд дахь АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх дотоод нөөц, боломжийг тодорхойлох
- АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж гаргах

3.1.3 Мониторингийн зохион байгуулалт

- Мониторингийн баг

Мониторингийн баг нь арга зүй анализийн ба тандах судалгааны баг гэсэн бүтцээр ажиллалаа. Арга зүй, анализийн баг нь зөвлөх, хоёр судлаачтай; тандах судалгааны баг нь төслийн судалгааны мэдээлэл цуглуулах 11 мониторингч /үүнээс төслийн 2 дугаар шатны мэдээлэл цуглуулах ажилд 9 мониторингч/; мэдээлэл оруулах, нээлттэй асуултыг кодлох үүрэгтэй хоёр мониторингч; шууд утсаар мэдээлэл хүлээн авах нэг мониторингч; төслийн зохицуулагч гэсэн нийт 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байв.

Мониторингийн судалгааны арга зүйг анализийн баг 2007 оны 7 дугаар сард тандалт, сурвалжилгын анкет, асуулга бүрийг боловсруулж сорил хийн, анкетуудыг эцэслэн боловсруулсан.

Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах дадлага, чадвар эзэмшүүлэх нэг өдрийн сургалтыг 2007 оны 8 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулав.

3.2 Мониторингийн аргачлал

3.2.1 Мониторингийн мэдээлэл бүрдүүлэх аргууд

Мониторингийн нэгдүгээр шатны мэдээллийг ажиглалт болон сурвалжилгын судалгаагаар бүрдүүлж, хоёрдугаар шатны мониторингийн суурь мэдээлэл болгон ашигласан.

Хоёрдугаар шатны мониторингийн мэдээллийг ажиглалт болон сурвалжилгын анкетын аргаар бүрдүүлж, мониторинг хоорондын харьцуулалтыг бичиг баримтын судалгаагаар баримтжуулав.

Ажиглалтын судалгаа. Мониторчид төрийн байгууллагуудаар явж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээллийн хүртээмж ямар түвшинд байгааг тодруулах зорилгоор судалгааны маягтын дагуу ажиглалт хийв.

Сурвалжилгын судалгаа. Төрийн байгууллагуудад ажиллаж буй ажилтан, албан тушаалтнуудаас тухайн байгууллагад АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж хэрэгжиж байгаа эсэхийг асууж лавлан, хэрэв хэрэгжиж байгаа бол явц нь ямар байгаа, үгүй бол ямар учраас гэдгийг тодруулж, мөн үйлчлүүлж буй иргэдээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг үнэлүүлсэн болно.

Сурвалжилгын анкетын судалгаа. Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтнуудаас тухайн байгууллага дахь зөвлөмжийг хэрэгжүүлэх суурь боломж, механизм, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр авч буй арга хэмжээний талаар тодруулан асууж, харин иргэдээс төрийн байгууллагуудаас мэдээллийг хэрхэн нээлттэй, хүртээмжтэйгээр авдаг, мөн иргэдийг үйл ажиллагаандаа оролцох боломжийг хэрхэн бүрдүүлж байгааг үнэлүүллээ.

Бичиг баримтын шинжилгээ. Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын, иргэдэд мэдээлэл түгээх хэлбэр болох тараах материал, вэб хуудас, мэдээллийн самбарын агуулгад анализ хийж; үйл ажиллагаатай нь холбоотой хууль, тогтоомж, дүрэм журмыг судлав.

Шүүд үтасны мэдээлэл. Хүнд суртал, чирэгдэл үүсгэн үйл ажиллагаандаа зөрчил гаргаж буй албан хаагчдын талаарх иргэдийн санал, гомдлыг 1977 дугаарын шууд утсаар 7 дугаар сараас эхлэн төсөл хэрэгжүүлэх хугацааны турш тогтмол хүлээн авч байв.

3.2.2 Мониторингийн хүрээ

Мониторингийн нэгдүгээр шатны судалгаанд хамрагдах төрийн байгууллагын тоог анх төлөвлөснөөс хоёр дахин нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагуудыг чиг үүрэг, тогтолцоогоор нь системтэй авч үзэх, түүнчлэн дээд, дунд, анхан шатны байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо болон иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмжийг цогц байдлаар судлахад илүү үр дүнтэй гэж үзсэн.

Мониторингийн нэгдүгээр шатны судалгаанд төрийн 110 байгууллага, 110 ажилтан, 110 албан тушаалтан, 330 үйлчлүүлэгч иргэнийг хамруулахаас:

- Ажиглалтын судалгаанд 107 байгууллага
- Сурвалжилгын судалгаанд 104 албан тушаалтан, 106 ажилтан
- Төрийн байгууллагаар үйлчлүүлэгч 319 иргэн оролцов.

Эхний шатны судалгаанд оролцохоос татгалзсан байгууллага, ажилтан, албан тушаалтнуудын хийсэн тайлбар:

Татгалзсан байгууллагууд:

- НОБГ нь иргэдэд үйлчилдэггүй, тусгай статустай байгууллага учир аливаа нэгэн судалгаанд хамрагдах боломжгүй гэсэн тайлбарыг өглөө.
- ТӨХ нь төрийн мэдэлд байгаа өмчийн харилцааг зохицуулдаг бөгөөд иргэдтэй өдөр тутам шууд харилцдаггүй тул иргэдээс судалгаа авах боломжгүй байлаа.
- ШБӨХЗГ нь иргэдтэй шууд харилцдаггүй бөгөөд зөвхөн монополь компаниудын хоорондын асуудлыг зохицуулдаг засгийн газрын тохируулагч агентлаг тул дээрхийн адил үйлчлүүлэх гэж очсон иргэн байхгүй байснаас судалгаа авах боломжгүй байв.

Татгалзсан албан тушаалтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ахлах гүйцэтгэгч Ч.Оюунцэцэг “Манай байгууллагад АТГ-аас зөвлөмж ирээгүй тул судалгаа өгөхгүй” гэв.
- ГССҮТ-ийн дарга “Одоо завгүй байгаа тул судалгааг дараа өгье” гээд дахин уулзах ба утсаар холбогдох боломж олгоогүй болно.
- БГД-ийн ТХ-ийн дарга амралтаа авсан тул нарийн бичгийн дарга нь даргын зөвшөөрөлгүй судалгаанд хамрагдах боломжгүй гэсэн албан тоот хийж өгөв.
- СБД-ийн Шүүхийн хяналтын прокурор Энхтуяа “Наад судалгаа чинь манай байгууллагатай ямар холбоотой юм бэ? Дүүргийн прокуророос очиж асуу. Даргын зөвшөөрөлгүй ямар ч судалгаа өгөхгүй, байгууллагадаа ч оруулахгүй” гээд харуулаа дуудаж судалгаа авахаар очсон мониторингийг хөөж гаргасан байна.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан дарга амарсан тул энэ судалгаанд оролцох боломжгүй хэмээн албан тоот өгсөн болно.
- НОБГ-аас албан тушаалтан судалгаанд оролцоогүй.

Татгалзсан ажилтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ажилтан даргын зөвшөөрөлгүйгээр судалгаанд хамрагдах боломжгүй хэмээв.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан судалгаанд оролцохгүй гээд албан тоот өгсөн тул ажилтан нь мөн хамрагдаагүй болно.
- ГССҮТ-ийн дарга судалгаанаас татгалзсан тул ажилтан нь мөн адил боломжгүй гэсэн хариу өглөө.
- НОБГ-ын ажилтнаас судалгаа авах боломжгүй байлаа.

Мониторингийн хоёрдугаар шатны судалгаанд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх 90 байгууллагыг хамруулав. Нэгдүгээр шатны мониторингийн судалгаанд хамрагдсан, иргэд цөөн үйлчлүүлдэг яамд болон хуулинд заасанчлан иргэдэд үйлчилдэггүй засгийн газрын агентлагуудыг 2 дугаар шатны судалгаанд дахин оруулах шаардлагагүй гэж үзсэн болно. Мониторингийн судалгаанд төрийн 90 байгууллага, 90 ажилтан, 90 албан тушаалтан, 450 үйлчлүүлэгч иргэнийг хамруулахаас:

- Ажиглалтын судалгаанд 90 байгууллага
- Сурвалжилгын анкетын судалгаанд 83 ажилтан, 81 албан тушаалтан
- Төрийн байгууллагаар үйлчлүүлэгч 430 иргэн тус тус хамрагдсан.

Хоёрдугаар шатны судалгаанд оролцохоос татгалзсан байгууллага, ажилтан, албан тушаалтнуудын хийсэн тайлбар:

Татгалзсан албан тушаалтнууд:

- ХУД-ийн Прокурорын газрын албан тушаалтан “Энэ судалгааг өмнө нь өгсөн учир оролцох шаардлагагүй” гэв.
- СБД-ийн цагдаагийн хэлтсийн албан тушаалтан “Манай байгууллага ЦЕГ-ын нэрэмжит иж бүрэн шалгалттай байгаа тул уг судалгаанд оролцох боломжгүй байна” гэсэн бичиг хийж өглөө.
- Улсын дээд шүүхийн дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга Ц.Түмэнбаяр болон санхүү хангамжийн үйлчилгээний албаны дарга нарт судалгаа авах учраа албан бичиг үзүүлж тайлбарлахад мониторингийг загнан, ёс зүйгүй харьцаж, заавал бичиг хэргээр дамжуул гэж шаардсан ба энэ тухай бичиг хэргээс нь лавлахад 30 орчим хоногийн дараа асуудал шийдэгдэх байх гэсэн хариу өгсөн тул судалгаа авч чадаагүй болно.
- СБД-ийн прокурорын газрын албан тушаалтан татгалзав.
- СБД-ийн замын цагдаагийн тасаг болон ХУД-ийн цагдаагийн хэлтсийн албан тушаалтан Энхболд мониторингийг судалгааны эхний 2 өдөр дараалан оруулаагүй бөгөөд дарга нь “Шалгалттай байгаа тул завгүй байна. Дараагийн долоо хоногт завтай болно” гээд хөөж гаргасан.
- Цагдаагийн Ерөнхий Газарын дотоод дэг журам хариуцсан офицер, хошууч М.Шагдаржав, бичиг хэргийн ажилтан ахлах ахлагч Уртнасан “Манайд тийм зүйл /зөвлөмж/ ирээгүй, ямар албан тоотоор явуулсныг нь мэдэж ир” гээд мониторингийг хөөж гаргасан.

Татгалзсан ажилтнууд:

- СХД-ийн цагдаагийн хэлтсийн албан тушаалтан Энхтөр “Ажилтнуудын эрх мэдлийн хэмжээнээс хэтэрсэн зүйл байна” гээд ажилтнуудаасаа судалгаа авахыг зөвшөөрөөгүй.
- СХД-ийн газрын албаны дарга Нямдаваа “Ажилтнуудаас судалгаа авах шаардлага байхгүй. Бүгдээрээ адилхан бэрхшээлтэй тулгарч байна”.
- СБД-ийн прокурорын газрын ажилтнууд “Завгүй, ажил ихтэй байна”. Хяналтын прокурор Сарангэрэл, Эрдэнэсүвд нар “Шаардлагагүй асуултанд хариулахгүй”.
- СБД-ийн замын цагдаагийн тасгийн ажилтан, ХУД-ийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Д.Энхжаргал болон ХУД-ийн цагдаагийн хэлтсийн ажилтан “Шалгалттай учир судалгаанд оролцох боломжгүй” гэсэн хариултыг өгч байлаа.

Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газар; Улсын Прокурорын Ерөнхий Газар; Үндэсний Татварын Ерөнхий Газар; Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар зэрэгт судалгаа хийх өдрүүдэд үйлчлүүлэгч иргэд байгаагүй болно.

Мөн өнгөрсөн хугацаанд нийт 348 иргэн холбогдож шууд утсаар төрийн үйлчилгээний байгууллагын ажилтан, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд гарсан зөрчилтэй холбоотой 330 гомдол, 18 саналыг тус тус ирүүлсэн байна.

Тараах материал, танилцуулах хуудастай гэсэн мэдээлэл өгсөн байгууллагуудаас 38 байгууллагын 93 тараах материал, танилцуулах хуудас; вэб сайттай гэсэн 39 байгууллагын сайтын мэдээлэлд агуулгын шинжилгээ хийж, судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдох Монгол улсын 26 хууль тогтоомжийг судлан үзсэн болно.

3.2.3 Мониторингийн судалгааны хугацаа

Мониторингийн судалгааг 2007 оны 7 дугаар сарын 1-нээс 2007 оны 12 дугаар сарыг дуустал зургаан сарын хугацаатай хийв. Мониторингийн тандалт, сурвалжилгын мэдээллийг 8 дугаар сард цуглуулж, суурь мэдээллээ бүрдүүлэн, эхний шатны судалгааны үр дүнг хэвлэлийн бага хурлаар олон нийтэд танилцуулсан болно.

Эхний шатны мэдээллийг 2007 оны 8 дугаар сарын 6-наас 10-ны хооронд; хоёрдугаар шатныхыг 10 дугаар сарын 8-наас 19-ний хооронд Улаанбаатар хотод байршилтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий улс, нийслэл болон дүүргийн хэмжээний байгууллагуудын ажилтан, албан тушаалтан, мөн тухайн байгууллагаар үйлчлүүлэгч иргэдээс бүрдүүллээ.

Бичиг баримтын судалгааг төслийн хугацаанд, судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудаас гаргадаг тараах материал, танилцуулах хуудас болон вэб сайтын мэдээллийн бүтцэд агуулгын шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, эрх хэмжээг заасан хуулийн заалтуудыг Монгол улсын хуулиас түүвэрлэн авч судлан үзэж хавсаргав.

1977 шууд утсаар иргэдийн санал, гомдлыг 2007 оны 7 дугаар сарын 7-ноос 12 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд хүлээн авсан бөгөөд, эхний таван сарын мэдээллийг энэхүү тайланд орууллаа.

Дөрөв. Төрийн байгууллагууд дахь АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийн талаархи хураангуйлсан үр дүн

4.1 Мэдээллийн хүртээмжтэй байдал

Зөвлөмж-1: *Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 81 хувь нь дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан байв. Дүрэм журмаа байрлуулаагүй байгууллагуудын албан тушаалтнуудаас энэ талаар тодруулахад самбараас өөр хэлбэрээр мэдээллээ хүргэдэг, самбараа түр хугацаанд авсан гэсэн хариултуудыг өгч байлаа.

Зөвлөмж-2: *Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих*

Тараах материалтай 63 байгууллагын 30 хувь нь албан тушаалтнуудынхаа эрх хэмжээ, мөн тэдний чиг үүргийг; 68 хувь нь иргэдийн бүрдүүлбэл зохих материал; 48 хувь нь үйлчилгээ үзүүлбэл зохих хугацаа; 72 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь зэргийг тараах материалдаа оруулжээ.

Үүнээс үзэхэд, төрийн байгууллагууд тараах материалаараа дамжуулан албан тушаалтнуудынхаа эрх хэмжээ, чиг үүрэг болон ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх талаар хангалтгүй мэдээлэл өгч байна.

Харин мэдээллийн самбартай 71 байгууллагын 64 хувь нь иргэдийн бүрдүүлбэл зохих материал, 57 хувь нь үйлчилгээг үзүүлбэл зохих хугацаа зэрэг шаардлагатай мэдээллийг байрлуулдаг байна. Мэдээллийн самбарт тараах материалын адилаар албан тушаалтнуудын эрх хэмжээ, чиг үүргийн талаарх мэдээлэл дутмаг байлаа.

Хоёр удаагийн мониторингийн судалгаанаас харахад төрийн байгууллагууд тараах материал, танилцуулгадаа тэр бүр зөвлөмжийн дагуу заагдсан мэдээллийг оруулаагүй байв.

Тараах материалыг мэдээлэл тавих зай багатай, иргэд бөөнөөр нь аваад явчихдаг учир тогтмол хэрэглээд байдаггүй гэсэн хариултыг өгч байсан.

Зөвлөмж-3: *Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 47 хувь нь вэб сайттай ч түүнээс 19 хувь нь л ажиллаж байсныг иргэдийн өгсөн мэдээлэл харуулж байна /иргэд байгууллагуудын 20 хувь нь вэб сайттай гэсэн мэдээлэл өгсөн/. Төрийн байгууллагаар үйлчлүүлэгч нийт 430 иргэний 9 хувь нь л дээрх вэб сайтуудаас ашиглаж үзжээ. Энэ нь нэг талаар вэб сайттай байгууллага цөөн, байсан ч тэр бүр иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг өгөх нөгөөтэйгүүр иргэдийн интернэтийн хэрэглээ харьцангуй байгаа зэрэгтэй холбоотой.

Вэб сайтгүй 44 байгууллагын хувьд төсөв санхүү /14 хувь нь/, иргэд хэрэглэж заншаагүй /10 хувь/, удирдах дээд байгууллагын вэб сайтаар дамжуулан мэдээллээ түгээдэг /14 хувь/, интернэтийн сүлжээ тавигдаагүй /24 хувь/ зэрэг шалтгаанаар сайтгүй байгаагаар тайлбарласан бол 33 хувь нь энэ талаар тодорхой хариулт өгөөгүй.

Вэб сайт ашигладаггүй 44 байгууллагын 25 хувь нь цаашид вэб сайттай болох төлөвлөгөөтэй гэсэн бол 75 хувь нь тодорхой хариулт өгөөгүй юм.

Байгууллагуудын 76 хувь нь тараах материал гаргадаг ч тэр нь тогтмол байж чаддаггүйгээс үйлчлүүлэгч иргэдийн 47 хувь нь л энэ талаар мэдэж байлаа. Мөн тэдгээр иргэдийн 54 хувь судалгаанд хамрагдсан 430 иргэний 23 хувь тараах материал ашигладаг гэсэн хариулт өгсөн. Төрийн байгууллагууд танилцуулгын материалаа тогтмол гаргаж чаддаггүйг нь харуулж байна.

Анхан шатны байгууллагуудын дийлэнх нь вэб сайтгүйгээс мэдээллээ удирдах дээд шатныхаа байгууллагын сайтаар дамжуулах нь хандралтэй байдаг байна. Тэдгээр байгууллагуудын 25 хувь нь ойрын хугацаанд /1-ээс 2 сар/ үйл ажиллагааныхаа танилцуулга, тараах материалыг гаргахаар бэлтгэж байгаа гэсэн нааштай хариу өгсөн.

Зөвлөмж-4: *Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн самбар болон вэб сайтанд байрлуулах*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 86 хувь нь мэдээллийн самбар ашигладаг ба эдгээрээс 97 хувь нь мод, цаасан зэрэг энгийн самбартай бол 3 хувь нь /Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар, Сонгино Хайрхан дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба/ электрон самбараар иргэдэд мэдээлэл түгээж байна.

430 иргэнээс 60 хувь нь самбарын мэдээлэл ашигладаг гэжээ.

Мэдээллийн самбартай 71 байгууллагын 76 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, 62 хувь нь уулзах ажилтны овог нэр зэргийг самбартаа байрлуулдаг байна. Харин иргэдтэй уулзах ажилтны утасны талаарх мэдээлэл дутмаг байсан.

Вэб сайттай 47 байгууллагын 48 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, 44 хувь нь уулзах ажилтны овог нэр зэргийг байрлуулдаг байна. Харин иргэдтэй уулзах ажилтны утасны талаарх мэдээлэл 40 хувьд нь байсан.

Зөвлөмж-5: *Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох*

Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 75 хувьд байна. Гэхдээ тэдгээр механизм нь ажилладаггүй бололтой.

Судалгаанд оролцсон 430 иргэний 33 хувь нь төрийн байгууллагуудад гомдол гаргаж байжээ. Тэдний 13 хувь нь асуудлаа шуурхай шийдвэрлүүлж чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарсан, 52 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байгаа нь дээрх байдлыг нотолж байна.

Зөвлөмж-6: Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх

Вэб сайттай 47 байгууллагын 44 хувь нь иргэд, хуулийн этгээдэд хэрэгтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ вэб сайтаараа мэдээлдэг бол нийт төрийн байгууллагын 18 хувь нь л мэдээллийн самбартаа тавьдаг байна.

Зөвлөмж-7:Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан зогсоох

Судалгаанд хамрагдсан байгууллагуудад хандсан иргэдийн 16 хувь нь үйлчилгээ хүртэхдээ ямар нэг хэмжээгээр төлбөр хураамж төлжээ. Засгийн газрын агентлагууд иргэдээс төлбөр хураамж ихээр авдаг байна. Харин прокурорын байгууллага төлбөр хураамж аваагүй байв. Төлбөр төлсөн иргэд дунджаар 1.3 төрлийн төлбөрт 22,372 төгрөг төлсөн байв.

Төлбөр төлсөн иргэдийн 34 хувь нь төрийн байгууллагаас авч буй төлбөрийг бодитой хэмээн хүлээн зөвшөөрч байсан бол 39 хувь нь эргэлзээтэй, 27 хувь нь бодитой бус, хэтэрхий өндөр гэж үзсэн.

Мөн төлбөр төлсөн иргэдийн 8 хувь нь БГД, БЗД, СБД, ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх албад болон Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрыг иргэдээс үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр авсан гэж үзсэн.

Төрийн байгууллагуудын иргэдээс төлбөр хураамж авч буй дээрх байдал нь хууль, журамд нийцсэн эсэх талаар хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх шаардлагатай гэдгийг баримтууд харуулж байна.

Төрийн 90 байгууллагын 56 хувь нь зөвлөмжийн дээрх заалтын дагуу арга хэмжээ авч эхэлсэн гэж хариулсан.

Зөвлөмж-8: Байгууллагуудын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гм/-ийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 78 хувь нь байгууллагын шийдвэртэй холбогдох материалууд, 56 хувь нь төсвийн зарцуулалттай холбоотой мэдээлэл, 48 хувь нь албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг зэргийг дотооддоо нээлттэй, ил тод байлгадаг байна.

Мэдээллээс үзэхэд байгууллагууд нь дотооддоо төсвийн зарцуулалт, болон албан тушаалтнуудынхаа хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байлгах талаар сул ажиллаж

байна. Үүний шалтгааныг ихэвчлэн хууль, дүрэм журмаар хязгаарласан байдагтай холбон тайлбарлаж байсан.

Мэдээллээ дотооддоо нээлттэй болгоогүй байгууллагуудын 40 хувь нь дээрх мэдээллийг ойрын 1-10 сарын дотор нээлттэй болгоно, 48 хувь нь одоогоор хариулт өгөх боломжгүй байна, 12 хувь буюу ЧД, СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар; СХД-ийн замын цагдаагийн тасаг; ЧД-ийн эрүүл мэндийн нэгдэл болон ЧД-ийн шүүх нь нээлттэй болгох боломжгүй гэсэн хариулт өгсөн.

Зөвлөмж-9: *Иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтаа тавих, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх*

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын вэб сайтын агуулга, чанарын талаар үйлчлүүлж байсан 430 иргэнээс тодруулахад тэдний 28 хувь нь вэб сайтаас өөрт хэрэгцээтэй мэдээллээ авч чаддаг, 16 хувь нь хангалттай биш, 20 хувь нь хэрэгцээтэй мэдээлэл бараг байдаггүй зэрэг хариулт өгсөн. Эндээс харахад төрийн байгууллагууд вэб сайтаараа дамжуулж иргэдэд хангалттай мэдээлэл өгч чадахгүй байна.

Танилцуулга, тараах материалын агуулга, чанарын талаар үнэлүүлэхэд 95 иргэний 48 хувь нь тэдгээр материалууд хэрэгцээтэй мэдээллийг агуулж чаддаг, 37 хувь нь зарим мэдээллээр дутмаг байдаг, 8 хувь нь хангалтгүй гэж хариулсан бол самбарын мэдээллээ хэр шинэчилдэг талаар үйлчлүүлэгч 366 иргэний 32 хувь нь тогтмол шинэчилдэг, 33 хувь нь алдаг оног, 13 хувь нь ер нь шинэчилдэггүй гэсэн хариултыг өгсөн. Мөн 366 иргэний 36 хувь нь мэдээллийн самбараас хэрэгцээтэй, 45 хувь нь зөвхөн зарим мэдээллийг авч чаддаг, 13 хувь нь зохих мэдээллээ авч чаддаггүй гэжээ.

Мөн байгууллагуудын 55 хувь нь иргэдэд мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтантай бөгөөд үүнийг иргэдийн дийлэнх ынь хангалттай мэдээлэл өгдөг бөгөөд харилцааны соёл сайтай хэмээн үнэлж байсан. Харин ажлын ур чадвар, гүйцэтгэл, шуурхай байдал зэрэг дээр дунд үнэлгээ илүү өгчээ.

Иргэд мэдээлэл өгөх ажилтанд илүү ач холбогдол өгсөн байна.

4.2 Үйл ажиллагаагаа нээлттэй байлгах талаар

Зөвлөмж-10: *Үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 74 хувьд иргэдэд үйлчлэх үйлчилгээний нээлттэй байдлыг хориглосон журам байдаггүй бол 18 хувьд нь зарим нэг журам байдаг байна.

Иргэдэд үйлчлэх тодорхой үйл ажиллагааны нээлттэй байдлыг хориглосон журам байдаг байгууллагуудад Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар; СБД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх газар; СБД-ийн засаг даргын тамгын газар; БГД, ХУД-ийн татварын хэлтэс; Нийслэл, БЗД, СХД-ийн прокурорын газар; Замын цагдаагийн газар; ЧД-ийн замын цагдаагийн тасаг; Нийслэл, СХД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар; Хот байгуулалт, Зураг төслийн хүрээлэн зэрэг газар ордог аж.

Зөвлөмж-11: *Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн хариуг өгөх*

Утсаар холбогдсон 330 иргэний 65 хувь гомдол гаргасан байгууллагадаа хандаад 1 сараас 2 жил, түүнээс дээш хугацаа өнгөрч байгаа ажээ. Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулж байгаа хугацааг тодорхой интервалуудад хувааж үзэхэд 35 хувь нь 1 сар хүртэлх хугацаа өнгөрч байгаа, 21 хувь нь 7 сараас нэг жил, 17 хувь нь 4-өөс 6 сар, мөн 12 хувь нь 2-оос дээш жил болж байв. Энэ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нэлээд чирэгдэлтэй байгааг харуулж байна.

Зөвлөмж-12: *Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаархи мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй болгох*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 88 хувь нь шийдвэр гаргах үйл ажиллагаагаа дотооддоо нээлттэй байлгадаг аж. Шийдвэр гаргах үндэслэл нь иргэдэд нээлттэй байх ёстой. Гэтэл иргэдийн 68 хувь нь энэ талаар мэдэхгүй, байгууллагууд хэрэгжүүлдэггүй гэсэн хариулт өгч байлаа. Харин нээлттэй байдаг хэмээн тэдний 29 хувь нь үзэж байв.

Зөвлөмж-13: *Төрийн байгууллага, албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүр тайлан гаргаж дүгнэж байх*

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын 51 хувьд нь албан тушаалтны үйл ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар тогтмол тайлагнадаг, 4 хувь нь энэ талаар нэмэлт тайлан гаргаж танилцуулдаг, 27 хувь нь дээрх тайлангаа дүгнэдэг, харин 2 хувь нь төрийн байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаа нээлттэй, ил тод, бүгд явцын хуралд суудаг учир тайлан гаргах шаардлагагүй, 0.5 хувь нь тайлан гаргадаггүй зэрэг хариултуудыг өгсөн.

4.3 Үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлэх талаар

Зөвлөмж-14: *Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 74 хувьд иргэдэд үйлчлэх үйлчилгээний нээлттэй байдлыг хориглосон журам байдаггүй, харин 18 хувьд нь байдаг аж.

Зөвлөмж-15: *Иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, эсхүл санал хүсэлтийн хайрцаг/дэвтэр/-ийг байрлуулан иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах*

Дээрх 90 байгууллагаас 63 хувь нь иргэдээс санал, гомдол хүлээн авах утас ажиллуулдаг байна. Гэтэл иргэдийн 4 хувь нь үүнийг мэдэж байсан бөгөөд тэдний 6 хувь нь л тус утсыг ашиглаж байжээ.

Мөн төрийн байгууллагуудын 63 хувь нь иргэдийн санал, гомдол хүлээн авах ажилтантай, харин энэ талаар үйлчлүүлэгч иргэдийн 26 хувь нь л мэдэж байсан. Санал,

хүсэлтийн хайрцаг, интернэт шуудан зэрэг бусад хэрэгслүүдийн ашиглалт дээрх хэлбэрийн адил мөн хангалтгүй байсан.

Түүнчлэн төрийн байгууллагуудаар үйлчлүүлж байсан иргэдийн 33 хувь нь урьд өмнө нь тухайн байгууллагадаа гомдол гаргаж байжээ. Тэдний 13 хувь нь асуудлаа шуурхай шийдвэрлүүлж чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарсан, 52 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байсан зэрэг нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангах тал дээр тавьдаггүй гэдгийг харуулж байна.

Зөвлөмж-16: *Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох*

Энэ талаар судалж үзэхэд маш хангалтгүй үзүүлэлттэй байна. Тухайлбал, 8 дугаар сарын мониторингоор төрийн 107 байгууллагаас энэ талаар тодруулж үзэхэд 51 хувь нь бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө иргэдээс санал авдаг гэж хариулсан бол 10 дугаар сард үйлчлүүлэгч нийт 430 иргэний 4 хувь нь л үүнийг хүлээн зөвшөөрч байв. Харин 9 хувь нь авдаггүй, үнэмлэхүй хувь нь /88 хувь/ энэ талаар мэдэхгүй байсан.

Зөвлөмж-17: *Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, тэдгээртэй танилцах боломжоор хангах*

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 8 хувь нь хууль тогтоомжид тус байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хориглосон байдаг, 92 хувь нь зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод байлгаж, танилцах боломжоор хангасан байлаа. Гадаад хэргийн яам; Газрын алба, АМГТХЭГ; Мөрдөн шалгах, цагдаагийн байгууллага; тамгын газруудад хэрэгжилт сул байна.

Тус зөвлөмжийг 4 яам, 5 агентлаг, дүүргүүдийн цагдаагийн 10 хэлтэс, 4 эмнэлэг, шүүх прокурорын 9 байгууллага хэрэгжүүлээгүй.

Мөн иргэдийн 19 хувь нь тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод нээлттэй байлгадаг, 33 хувь нь өмнөхөө бодвол сайжирсан, 33 хувь нь нээлттэй биш, 45 хувь нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн.

Зөвлөмж-18: *Байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийг боловсронгуй болгож, тэр дундаа ямар ёс зүйг ажилтнууд сахих талаарх заалтуудыг иргэдэд нээлттэй болгох*

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий судалгаанд хамрагдсан 90 байгууллагын 55 хувь нь ажилтнуудынхаа ёс зүйн заалтуудыг иргэдэд нээлттэй болгосон байна., Үйлчлүүлэгч иргэдийн 16 хувь нь албан хаагчид харьцааны соёл сайтай, тэдний ёс зүйн дүрэм нээлттэй ил тод байдаг, харин 46.5 хувь нь хаалттай, 27 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Гадаад хэргийн яам; Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжилт сул байна.

Ёс зүйн дүрмээ судалгаанд хамрагдсан 90 байгууллагын 28 хувь нь мэдээллийн самбартаа, вэб сайттай байгууллагуудын 36 хувь нь сайтдаа тус тус байршуулжээ.


Тав. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт, орчин, нөхцөл байдал

5.1 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын идэвх, санаачлага

5.1.1 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн талаар төрийн байгууллагууд хэр мэдээлэлтэй байна вэ?

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагаас АТГ-ын “Төрийн байгууллагын үйл ажиллагааны хүртээмж, ил тод байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх” зорилготой гурван бүлэг 18 зүйл бүхий зөвлөмжийн талаар хэр мэдээлэлтэй байгааг тодруулахад, байгууллагуудын 13 хувь нь ямар ч мэдээлэлгүй, 34 хувь нь зөвхөн тойм мэдээлэл авсан, 12 хувь нь уншиж судалж байгаа, 41 хувь нь зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.


График 1. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн талаар төрийн байгууллагууд хэр мэдээлэлтэй байна вэ?



БГД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; БЗД-ийн засаг даргын тамгын газар; БГД, БЗД, СХД-ийн татварын хэлтэс; ЧД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; ЧД-ийн прокурорын газар; БЗД-ийн замын цагдаагийн тасаг; БГД, СХД-ийн эрүүл мэндийн нэгдэл зөвлөмжийн тухай ямар ч мэдээлэлгүй байв.

Харин АТГ нь гаргасан зөвлөмжийнхөө мөрөөр үйл ажиллагаагаа идэвхжүүлснээр урьд өмнө нь тус зөвлөмжийн талаар тойм мэдээлэл авсан байгууллагууд /34 хувь/-ын хувь 68 болтлоо өссөн байна.

График 2. Төрийн байгууллагууд Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн мэдээллийг хэдийд хүлээж авав?




Зөвлөмжийн талаархи мэдээлэл нь судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагуудын 38 хувьд удирдлагын зүгээс албан тоотоор танилцуулах хэлбэрээр, 29 хувьд АТГ-аас хийсэн сургалт, семинар; 24 хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслээр; 10 хувьд бусад сувгаар дамжин хүрчээ. Нийгмийн даатгалын газар, хэлтэс, шүүхийн талаас илүү хувь нь мэдээлэл муутай байна.

Зөвлөмжийг судлах шатандаа байгаа 38 байгууллагын 40 хувь нь 6 дугаар сард, үлдсэн 60 хувь нь 9 дүгээр сараас хойш зөвлөмжтэй танилцжээ.

Харин байгууллагуудын 31 хувь нь 4, 5 дугаар сард; 38 хувь нь 9 дүгээр сараас хойш зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

График 3. Байгууллагуудын АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж эхэлсэн хугацаа



АТГ-ын зөвлөмжийн талаарх мэдээлэл нь Татварын ерөнхий газар, албад; Нийгмийн даатгалын газар, хэлтэс; Шүүх; Замын цагдаагийн газар, тасаг; Засаг даргын тамгын газар; Цагдаагийн ерөнхий газар, хэлтэс; Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, алба; Прокурор; Эмнэлэг; Газрын алба болон Засгийн газрын агентлагуудад хангалтгүй байлаа.

Хүснэгт 1. АТГ-ын зөвлөмжийн талаар төрийн байгууллагууд хэр мэдээлэлтэй байна вэ? Байгууллагын чиг үүргээр /хувь/

	Мэдэхгүй	Сонссон юм байна	Уншиж судалж байгаа	Хэрэгжүүлэхээр ажиллаж байна
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба	12.5	25.0	-	62.5
Засаг даргын тамгын газар	14.3	42.9	-	42.9
Татварын газар, хэлтэс	37.5	25.0	12.5	25.0
Нийгмийн даатгалын газар, хэлтэс	25.0	50.0	-	25.0
Цагдаагийн ерөнхий газар, хэлтэс	-	25.0	25.0	50.0
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, алба	-	25.0	25.0	50.0
Прокурорын газар	16.7	16.7	16.7	50.0
Замын цагдаагийн газар, тасаг	16.7	33.3	33.3	16.7
Эмнэлэг	22.2	33.3	-	44.4
Газрын алба	-	28.6	-	71.4
Шүүх	-	57.1	28.6	14.3
Засгийн газрын агентлаг	-	40.0	20.0	40.0
Нийт	13.3	33.7	12.0	41.0

Жич: Засгийн газрын агентлагт Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар; Иргэний бүртгэл мэдээллийн төв; Эд хөрөнгө улсын бүртгэлийн газар; Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар; Хот байгуулалт зураг төслийн хүрээлэнг хамруулав

Байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах эрх хэмжээгээр нь харьцуулбал дээд болон анхан шатны байгууллагуудад АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилт дунд шатны байгууллагуудынхаас харьцангуй сул байна.

Хүснэгт 2. АТГ-ын зөвлөмжийн талаар төрийн байгууллагууд хэр мэдээлэлтэй байна вэ? Байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх хэмжээгээр /хувь/

	Мэдэхгүй	Сонссон юм байна	Уншиж судалж байгаа	Хэрэгжүүлэхээр ажиллаж байна
Улс	-	36.4	18.2	45.5
Нийслэл		36.4	-	63.6
Дүүрэг	18.0	32.8	13.1	36.1
Нийт	13.3	33.7	12.0	41.0

5.1.2 Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар төрийн байгууллагууд хэр анхаарч байна?

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 69 хувь нь албан хаагчиддаа хууль дүрмийнхээ дагуу ажиллах; АТГ-ын зөвлөмжийг танилцуулах; үйлчилгээгээ сайжруулах; үйл ажиллагааныхаа талаархи мэдээллийг нээлттэй, ил тод болгох; зөвлөмжийг мөрдлөг болгож ажиллах зэргээр ерөнхий үүрэг даалгавар өгчээ.

График 4. Төрийн байгууллагын удирдлагаас албан хаагчиддаа өгсөн үүрэг даалгавар



* Жич: Бусад гэдэгт зөвлөмжийг хэрэгжүүлэх бусад арга, хэлбэр гэсэн утгыг агуулсан болно.

Харин дээрх байгууллагын 12 хувь нь ямар ч үүрэг даалгавар өгөөгүй, 19 хувь нь зөвлөмжийн дагуу арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байв.

График 5. Төрийн байгууллагын удирдлагууд АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ажилтнууддаа хэдийд үүрэг өгөв?





График 5-аас үзэхэд 9 дүгээр сард буюу мониторингийн эхний үр дүнг танилцуулсны дараа харьцангуй олон буюу 38 хувь нь байгууллага албан хаагчиддаа АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг даалгавар өгчээ. Харин 6, 7 дугаар саруудад хамгийн бага хувьтай байв. /Энэ нь ээлжийн амралт авах гэх мэт улирлын байдалтай холбоотой гэж үзэв/

5.1.3 Төрийн байгууллагуудад Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт байна үү?

Байгууллагын үйл ажиллагааны үр дүн нь түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн алба эсвэл албан тушаалтан байгаа эсэх, тэдний хэрхэн ажиллахаас шууд хамааралтай байдаг. Бид энэ талаар судалж үзэхэд төрийн 90 байгууллагын 39 хувь нь АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий тодорхой ажилтан томилон ажиллуулж байв. Харин 20 хувьд нь ийм ажилтан байхгүй ба 41 хувьд байгаа эсэх нь тодорхойгүй байв.

График 6. Төрийн байгууллагуудад АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан бий юү?



Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба; Цагдаагийн газар, хэлтэс болон Газрын алба зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг харуулсан тодорхой үүрэгтэй ажилтантай байлаа.

Хүснэгт 3. Төрийн байгууллагуудад АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан бий юү?

Байгууллагуудын чиг үүргээр /хувь/


	Байгаа	Байхгүй	Тодорхойгүй
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба	62.5	12.5	25.0
Засаг даргын тамгын газар	28.6	28.6	42.9
Татварын газар, алба	37.5	12.5	50.0
Нийгмийн даатгалын газар, хэлтэс	12.5	-	87.5
Цагдаагийн газар, хэлтэс	50.0	25.0	25.0
Хөдөлмөр халамжийн газар, алба	25.0	50.0	25.0
Прокурорын газар	33.3	33.3	33.3
Замын цагдаагийн газар, тасаг	50.0	-	50.0
Эрүүл мэндийн байгууллага	44.4	-	55.6
Газрын алба	57.1	28.6	14.3
Шүүх	28.6	57.1	14.3
Засгийн газрын агентлаг	40.0	-	60.0
Нийт	38.6	20.5	41.0

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар; Нийслэл, БЗД, СБД, СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Нийслэл, ЧД-ийн засаг даргын тамгын газар; Нийслэл, ЧД, ХУД-ийн татварын хэлтэс; СБД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БЗД, СХД-ийн цагдаагийн хэлтэс; СБД, ХУД-ийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний алба; Улсын прокурорын ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газар; Замын цагдаагийн газар; ЧД, ХУД-ийн замын цагдаагийн тасаг; УК-1, УК-2-р эмнэлэг; БЗД, СБД-ийн эрүүл мэндийн нэгдэл; Нийслэл, БЗД, СБД, СХД-ийн газрын алба; БЗД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар; Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан байдаг юм байна.

5.1.4 Төрийн байгууллагууд АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд ямар арга хэмжээ авч байна вэ?

АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж буй төрийн байгууллагуудын хувьд мэдээлэл, үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулах; мэдээллийн самбараа тогтмол шинэчлэх; гарын авлага, танилцуулах материал тараах; мэдээллийн самбар гаргаж ажиллуулах; ажилтан, албан тушаалтнууддаа зөвлөмжийг танилцуулах зэрэг арга хэмжээ авчээ.

График 7. АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагуудаас авч буй арга хэмжээ.



Дээрх мэдээллийг байгууллагын үйл ажиллагааных нь чиглэлээр харьцуулахад Шүүхийн шийдвэр биелүүлэх газар болон Замын цагдаагийн газар иргэдэд мэдээлэл өгөх; Газрын албанаас танилцуулах хуудас тараах; Татварын газар, алба мэдээллийн самбараа тогтмол шинэчлэх; Нийгмийн даатгалын газар болон Шүүх нь ажилтан, албан тушаалтнууддаа зөвлөмжийг танилцуулах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.

Цаашид байгууллагуудын 26 хувь нь ажилтан, албан тушаалтнууддаа сургалт семинар; 22 хувь нь өдөрлөг, аян зохион байгуулах зэргээр зөвлөмжийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байв. Харин 4 хувьд зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн зүйлгүй, 17 хувь нь ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байна.

График 8. АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд цаашид төлөвлөж буй ажлууд



5.2 Төрийн байгууллагууд дахь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт

Аливаа ажил, санаачлагыг хэрэгжүүлэхэд тодорхой нөхцөл байдал болон түүнд шаардлагатай нөөц боломж хэрхэн бүрдсэнээс шалтгаалан хаанаас эхлэж, юу хийхээ төлөвлөх нь менежментийн үндсэн хууль байдаг.

Бид албан тушаалтнууд байгууллагынхаа дотоод үйл ажиллагааны талаар илүү бодитой мэдээлэл өгч чадна гэж үзсэн тул тэднээс АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх нөөц боломж байгууллагуудад нь бий эсэхийг тодруулахаар судалгаа авлаа.

Харин төрийн байгууллагуудад зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг иргэдээр үнэлүүлэв.


Түүнчлэн ажилтан, албан тушаалтан болон үйлчлүүлэгч иргэдийн мэдээллийн үнэн бодит байдлыг ажиглалт, мөн бичиг баримтад агуулгын шинжилгээ хийж баримтжуулсан болно.

5.2.1 Төрийн байгууллагуудын мэдээллийг хүртээмжтэй байлгах дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт

АТГ-ийн зөвлөмж бичигт заасанчлан төрийн байгууллагууд иргэдэд үйл ажиллагааныхаа талаархи мэдээллийг вэб сайт, мэдээллийн самбар болон тараах материал танилцуулах хуудас зэрэг хэлбэрээр түгээх үүрэгтэй.

Энэ байдлыг тандаж үзэхэд судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 76 хувь нь тараах материал, танилцуулах хуудас; 86 хувь нь мэдээллийн самбар; 47 хувь нь вэб сайт; 55 хувь нь иргэдэд мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан; 10 хувь нь бусад хэлбэрийг ашигладаг байна.

График 9. Төрийн байгууллагуудын мэдээлэл түгээдэг эх үүсвэрүүд ба түүний хэрэгжилт



**Хүснэгт 5. Төрийн байгууллагуудын мэдээлэл түгээх хэлбэрүүд
Байгууллагын чиг үүргээр /хувь/**

	Тараах материал, танилцуулах хуудас	Мэдээллийн самбар	Вэб сайт	Мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба	100.0	87.5	100.0	75.0
Засаг даргын тамгын газар	71.4	57.1	42.9	71.4
Татварын газар, хэлтэс	100.0	100.0	75.0	75.0
Нийгмийн даатгалын газар, хэлтэс	75.0	87.5	37.5	75.0
Цагдаагийн газар, хэлтэс	75.0	75.0	-	25.0
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, алба	100.0	87.5	62.5	37.5
Прокурорын газар	33.3	66.7	33.3	33.3
Замын цагдаагийн газар	50.0	83.3	50.0	66.7
Эмнэлэг	66.7	88.9	22.2	55.6
Газрын алба	71.4	100.0	28.6	-
Шүүх	57.1	85.7	-	42.9
Засгийн газрын агентлаг	100.0	100.0	100.0	100.0


Судалгаанд хамрагдсан 90 байгууллагын 20 хувьд байгууллагын үйлчилгээний тухай; 4 хувьд гаргасан шийдвэр, түүний үндэслэлийн тухай; 6 хувьд ажилтан, албан тушаалтнуудын ёс зүйн талаархи мэдээлэл; 22 хувьд дотоод дүрэм журам, түүний хэрэгжилт; 2 хувьд үйлчилгээний хураамж; 0.4 хувьд хамтран ажилладаг байгууллагууд; 8 хувьд үйл ажиллагаандаа мөрддөг хууль тогтоомжийн талар болон 19 хувьд тухайн байгууллагатай холбоотой бүх төрлийн хэрэгцээтэй мэдээлэл байсан байна.

Харин 430 иргэний 29 хувь нь л хэрэгцээтэй мэдээллээ дээрх болон бусад хэлбэрээр олж авдаг гэсэн нь нэлээд хангалтгүй үзүүлэлт бөгөөд мэдээлэл олж авч буй суваг цөөн, мөн мэдээллийн агуулгын чанар муу гэсэн үг юм.

А. Тараах материал, танилцуулга

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 76 хувь нь тараах материал, танилцуулах хуудсыг ашигладаг. Тараах материал ашигладаг 69 байгууллагын 60 хувь нь тогтмол, 37 хувь нь хааяа, 3 хувь нь бараг тараадаггүй байна.

График 10. Тараах материал, танилцуулга ашиглалт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, алба; Газрын алба; Засгийн газрын агентлаг тараах материалаар иргэдэд тогтмол үйлчилдэг байна. Ялангуяа Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын тараах материалууд нь төрөлжсөн агуулга, стандартын хувьд иргэдийн хэрэгцээг хангахаар чанартай хийгдсэн байсныг онцлох нь зүйтэй юм.

Байгууллагууд тараах материал ашиглахгүй байгаагаа төсөв санхүүгийн хүрэлцээ муутайгаас шалтгаалдаг хэмээн тайлбарлаж байв. Дээрх байгууллагуудын 25 хувь нь ойрын хугацаанд /1-ээс 2 сар/ үйл ажиллагааныхаа талаар танилцуулга, тараах материал гаргахаар зэхэж байгаа гэсэн нааштай хариу өгсөн. Түүнчлэн зарим байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор тараах материалаас бусад мэдээлэл түгээх өөр хэлбэрийг ашигладаг нь иргэдэд илүү үр өгөөжтэйн дээр зардал бага ордог ач холбогдолтой юм байна. Үйлчлүүлэгч 95 иргэнээр байгууллагуудын танилцуулга, тараах материалын агуулга, чанарыг үнэлүүлэхэд тэдний 48 хувь нь хэрэгцээтэй мэдээллийг агуулж чаддаг, 37 хувь нь зарим талаар дутмаг, 8 хувь нь хангалтгүй гэсэн байна.

Засаг даргын тамгын газар, Татварын газар, хэлтэс, Эрүүл мэндийн байгууллага болон Шүүхүүдийн тараах материалын агуулга сайн; Цагдаагийн газар, хэлтэс, Газрын албадынх дунд; Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албаных хангалтгүй байв.

Тараах материалтай байгууллагуудын 30 хувь нь тараах материалдаа үйл ажиллагааныхаа чиг үүрэг, албан тушаалтнуудын эрх хэмжээ, үүргийг; 68 хувь нь иргэдийн бүрдүүлбэл зохих материал, 48 хувь нь үйлчилгээг үзүүлэх хугацаа; 72 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; 51 хувь нь уулзах ажилтны овог нэр; харилцах утас зэргийг тус тус оруулжээ.

Үүнээс үзэхэд байгууллагууд иргэдэд албан тушаалтнуудынхаа эрх хэмжээ, үүрэг болон иргэдтэй уулзах ажилтантай холбоо барих утасны талаарх мэдээллийг хангалтгүй өгч байна.

График 11. АТГ-ын зөвлөмжийн дагуу төрийн байгууллагууд тараах материал, танилцуулгадаа багтаавал зохих шаардлагатай мэдээллүүд



Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба нь албан тушаалтнуудын чиг үүрэг, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; Замын цагдаагийн газар, тасаг иргэдийн бүрдүүлбэл зохих материал, үйлчилгээг үзүүлбэл зохих хугацаа; Замын цагдаагийн газар, тасгууд нь иргэдийн бүрдүүлбэл зохих материал, үйлчилгээг үзүүлбэл зохих хугацаа; хүлээн авч уулзах цагийн хуваарь; Газрын албад, Шүүхүүд иргэдийн бүрдүүлбэл зохих материал, хүлээн авч уулзах цагийн хуваарь зэргийг тараах материалдаа тус тус оруулжээ. Харин Замын цагдаагийн газар, тасаг болон Газрын алба нь иргэдтэй уулзах ажилтны утас, чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлбэл зохих хугацааг оруулаагүй байв.


Б. Мэдээллийн самбар

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 86 хувь нь мэдээллийн самбар ашигладаг. Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар, Сонгино Хайрхан дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба электрон самбараар мэдээлэл түгээж байгаа нь дэвшилттэй алхам болжээ.

Самбар ажиллуулдаг байгууллагуудаас мэдээллээ шинэчилдэг давтамжийг нь тодруулахад 17 хувь нь өдөр бүр; 4 хувь нь 2-3 өдөрт 1 удаа, 41 хувь нь 7 хоногт нэгээс цөөнгүй удаа; 17 хувь нь сард 2-оос цөөнгүй удаа; харин 3 хувь нь /Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх газар болон ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс/ шинэчлэх шаардлагагүй; 6 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг тус тус өгчээ.

Төрийн байгууллагууд самбарын мэдээллээ тогтмол шинэчилдэг эсэхийг үйлчлүүлэгч иргэдээс тодруулахад 32 хувь нь тогтмол, 33 хувь нь алдаг оног, 13 хувь нь шинэчилдэггүй гэсэн хариултыг өгсөн. Харин иргэдийн 36 хувь нь мэдээллийн самбараас хэрэгцээтэй мэдээлэл, 45 хувь нь зөвхөн зарим мэдээллийг авч чаддаг харин 13 хувь нь хүссэн мэдээллийг авч чаддаггүй гэжээ.

График 12. Төрийн байгууллагууд мэдээллийн самбараар дамжуулж иргэдэд хангалттай мэдээлэл өгч чадаж байна уу?



Судалгаанд оролцсон 430 иргэний үнэлгээгээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, алба, Засгийн газрын агентлагууд самбарын мэдээллээ тогтмол шинэчилдэг; Засаг даргын тамгын газар, Шүүхүүдийн самбар хэрэгцээтэй мэдээллийг агуулсан байдаг. Харин Цагдаагийн ерөнхий газар, тасгууд мэдээллээ шинэчлэх тал дээр тааруухан, Прокурорын газрууд хэрэгцээтэй мэдээллийг самбартаа байрлуулдаггүй гэжээ.

Байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах” гэсэн заалтын хэрэгжилтийн байдлыг судалгаанаас үзэхэд 8 дугаар сард 107 байгууллагын 54 хувь нь хангалттай гэсэн үзүүлэлттэй байсан бол 10 дугаар сарын ажиглалтаар /90 байгууллагын/ 81 хувь болж эрс сайжирчээ. Харин иргэдээс тодруулахад, мэдээллийн самбартай байгууллагуудын 91 хувь нь хэрэгжүүлж байна, 6 хувьд хэрэгжээгүй хэмээн тус тус хариуллаа.

8 дугаар сард 107 байгууллагын 57 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, мэдээллийн самбарт байрлуулсан бол 10 дугаар сард 90 байгууллагын 63 хувь болж өсчээ. Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албад уг заалтыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн Засаг даргын тамгын газруудад эрс сайжирсан, харин Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, албад болон засгийн газрын агентлагуудад зөвлөмжийн заалтын хэрэгжилт буурчээ.

Мэдээллийн самбаргүй байгууллагууд самбартай болоход ямар нэг хүндрэл байхгүй, эсвэл хийгдэж байгаа, цаашид самбартай болох төлөвлөгөөтэй гэх зэргээр хариулжээ.

СБД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Нийслэл, БГД, БЗД-ийн засаг даргын тамгын газар; БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БЗД-ийн цагдаагийн хэлтэс; Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; ЧД, СХД-ийн прокурорын газар; ХУД-ийн замын цагдаагийн тасаг; ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; Нийслэлийн шүүх Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; БЗД-ийн татварын хэлтэс; ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс;; БЗД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; БЗД-ийн прокурорын газар; 2 дугаар төрөх газар; БГД-ийн газрын алба; Улсын дээд шүүх; БГД, ХУД-ийн шүүх, Эд хөрөнгийн, улсын бүртгэлийн төв зэрэг байгууллагууд мэдээллийн самбаргүй байлаа.

График 13. АТГ-ын зөвлөмжийн дагуу төрийн байгууллагууд мэдээллийн самбартаа шаардлагатай мэдээллийг байрлуулсан байдал



АТГ-ын зөвлөмжийн дагуу төрийн байгууллагууд дээрх мэдээллийг самбартаа байрлуулах шаардлагатай. Үүнийг үйлчлүүлэгч иргэдээс тодруулахад мэдээллийн самбартай байгууллагуудын 76 хувь нь иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, 64 хувь нь иргэдийн бүрдүүлбэл зохих материал, 62 хувь нь уулзах ажилтны овог нэр, 60 хувь нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм журам, 57 хувь нь үйлчилгээг үзүүлбэл зохих хугацаа зэргийг байрлуулдаг байна. Харин албан тушаалтнуудын эрх хэмжээ, чиг үүрэг; иргэдтэй уулзах ажилтны утас; албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм; иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэр болон түүний үндэслэл мэдээллийн самбарт тэмдэглэгдээгүй байв.

Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албад үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм журам; албан тушаалтнуудын эрх хэмжээ, чиг үүрэг; иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; иргэдтэй уулзах ажилтны овог нэр зэргийг тогтмол байрлуулдаг. Шүүхүүд иргэдийг хүлээн авч уулзах ажилтны цагийн хуваарь; Засгийн газрын агентлагууд иргэдийн

бүрдүүлбэл зохих материалыг мэдээллийн самбартаа тус тус тавьдаг байна. Харин Засаг даргын тамгын газрууд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрууд нь иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд шаардлагатай мэдээлэл; Прокурорын газруудад албан тушаалтнуудын ёс зүйн дүрмийг байрлуулаагүй байв.

В. Вэб сайт

8 дугаар сард төрийн 107 байгууллагын 52 хувь нь вэб сайттай байсан бол 10 дугаар сард 90 байгууллагын 47 хувь болж буурсан байна.

Судалгаагаар ирсэн мэдээллийг баримтжуулах зорилгоор төрийн байгууллагын вэб хаяг болон www.pmis.gov.mn сайтаар орж баримтын судалгаа хийхэд дээрх вэб сайттай байгууллагуудын 53 хувьд вэб холбогдохгүй, 18 хувь нь салбар байгууллагынхаа нэгдсэн хаягийг, харин 3 хувь нь өөр байгууллагуудын вэб хаягийг тус тус өгсөн байв.

Вэб сайттай байгууллагуудын вэб дэх мэдээллийн агуулгад шинжилгээ хийж үзэхэд Чингэлтэй, Сонгино Хайрхан, Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газруудад танилцуулга, хууль тогтоомжоос өөр мэдээлэл байгаагүй бөгөөд мэдээллээ 3-аас 22 хоногийн өмнө шинэчилсэн байлаа.

Вэб сайтын мэдээллийн агуулга, чанарын талаар судалгаанд оролцсон 430 иргэнээс тодруулахад тэдний 28 хувь нь хэрэгцээтэй мэдээллээ авч чаддаг, 16 хувь нь хангалттай биш, 20 хувь нь хангалтгүй гэсэн хариултыг тус тус өгчээ. Дээрх баримтуудаас үзэхэд байгууллагуудын үнэмлэхүй хувь нь вэб сайтаараа дамжуулан хангалттай мэдээлэл өгч чадахгүй байна. Бусад 36 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.

Иргэдийн үнэлгээгээр Шүүх болон Засгийн газрын агентлагууд вэб сайтынхаа мэдээллийг шинэчлэх тал дээр анхаарлаа хандуулж ажилладаг бол Татварын ерөнхий газар, хэлтэс, Шүүх байгууллага, Засгийн газрын агентлагуудын вэб нь хэрэгцээтэй мэдээлэлтэй байдаг байна. Иргэд ялангуяа <http://www.parl.gov.mn> болон <http://www.open-government.mn> багц сайтуудыг илүү сайшаажээ. Харин Прокурорын газрууд вэб сайтаа огт шинэчилдэггүй бөгөөд хэрэгцээтэй мэдээлэл ч тавьдаггүй тухай ярьж байлаа.

График 14. АТГ-ын зөвлөмжийн дагуу төрийн байгууллагууд вэб сайтдаа шаардлагатай мэдээллийг байрлуулсан байдал



Судалгаанд хамрагдсан байгууллагууд вэб сайтдаа үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм журам, иргэдийн бүрдүүлбэл зохих материал, үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх тухай мэдээллүүдийг түлхүү оруулсан байна. Харин албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм, тодорхой шийдвэрүүдийн талаарх мэдээлэл хангалтгүй байна.

90 байгууллагын 14 хувь нь төсөв санхүүгийн хүндрэл, 10 хувь нь иргэд хэрэглэж заншаагүй, 14 хувь нь удирдах дээд байгууллагын вэб сайтаар дамжуулан мэдээллээ түгээдэг, 24 хувь интернэтийн сүлжээ тавигдаагүй зэрэг шалтгаанаар сайтгүй байгаагаар тайлбарласан бол 33 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.

Вэб сайт ашигладаггүй байгууллагуудын 25 хувь нь цаашид вэб сайттай болох төлөвлөгөөтэй, харин 75 хувь нь тодорхой хариулт өгсөнгүй.

Г. Иргэдэд мэдээлэл өгөх ажилтан

Судалгаанд хамрагдсан 90 байгууллагын 45 хувьд иргэдэд мэдээлэл өгөх үүрэгтэй тусгай ажилтан байдаггүй бөгөөд ийм ажилтантай болох орон тоо байхгүй, хэрэгцээ, шаардлага нь гараагүй байна гэсэн хариултыг тус тус өгчээ. Эдгээр байгууллагуудын дөнгөж 5 хувь нь л цаашид иргэдэд мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтантай болох төлөвлөгөөтэй байгаа, харин 92 хувь тодорхой хариулт өгөөгүй.

Иргэдийн 60 хувь нь төрийн байгууллагуудын мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтнуудыг харилцааны соёл сайтай гэж үнэлсэн, харин ажлын ур чадвар, гүйцэтгэл, шуурхай байдал зэрэгт дунд үнэлгээ өгөх нь илүүтэй байлаа.

Мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан нь хангалтгүй үнэлгээ авсан байгууллагуудыг дурьдвал: Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх газар; СХД-ийн засаг даргын тамгын газар; ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; Улсын цагдаагийн ерөнхий газар; Замын цагдаагийн газар; СХД-ийн замын цагдаагийн тасаг; БЗД-ийн газрын алба; Улсын дээд шүүх, СБД-ийн шүүх зэрэг болно.

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар; БГД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; БГД, СБД-ийн засаг даргын тамгын газар; БГД, ХУД-ийн татварын хэлтэс; СХД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БГД, БЗД, СХД-ийн цагдаагийн хэлтэс; Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний газар; Нийслэл, ЧД, СБД, СХД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Улсын прокурорын ерөнхий газар; Нийслэл, БЗД, СХД-ийн прокурорын газар; БГД, БЗД-ийн замын цагдаагийн тасаг; УК-1-р эмнэлэг; БЗД, СХД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; Нийслэл, БГД, БЗД, ЧД, СБД, СХД, ХУД-ийн газрын алба; БГД, ЧД, СБД, СХД-ийн шүүх зэрэг байгууллагад дээр дурьдсан ажилтан байхгүй байна.

Д. Төрийн байгууллагын мэдээлэл түгээх хэлбэрүүдийн талаарх нэмэлт мэдээлэл

Судалгаанд оролцсон иргэд төрийн байгууллагын мэдээлэл түгээх хэлбэрүүдээс мэдээлэл өгөх тусгай ажилтан болон тараах материалыг сонгож авах нь илүүтэй байна. Түүнчлэн, нэг цэгийн үйлчилгээ, иргэдэд зориулсан сургалт семинар, электрон самбар зэрэг дэвшилтэт шинэ төрлийн үйлчилгээнүүдийг сайшаан дурьдсан байлаа.

Е. Байгууллагын төлбөр, тооцоотой холбоотой нэмэлт мэдээлэл

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудад хандсан иргэдийн 16 хувь нь үйлчилгээ хүртэхдээ ямар нэг хэмжээгээр төлбөр хураамж төлжээ.

График 15. Иргэдээс төлбөр хураамж авсан байгууллагууд



График 26-аас үзэхэд Засгийн газрын агентлагуудын иргэдээс авдаг төлбөр хураамжийн хэмжээ бусад байгууллагуудыг бодвол их байдаг, харин Прокурорын байгууллагууд төлбөр авдаггүй байна.

Судалгаанд оролцсон иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ үйлчилгээний төлбөрт дунджаар 22,372 төгрөг төлсөн ба энэ нь нэг үйлчилгээнд дунджаар 10,000 төгрөгийн хураамж төлсөн гэсэн үг юм. Байгууллагуудыг үйл ажиллагааных нь чиглэлээр харьцуулахад Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албад хамгийн өндөр буюу 31600 төгрөг; Газрын албад 17600 төгрөг; Нийгмийн даатгалын газар, албад 12000 төгрөг; Замын цагдаагийн газар, тасгууд нэг иргэнээс 11500 төгрөгийн хураамж тус тус авчээ. Байгууллагуудыг эрх хэмжээгээр нь харьцуулбал нэг иргэнээс дээд шатны байгууллага дунджаар 16600 төгрөг; нийслэлийн харъяалалтай буюу дунд шатны байгууллагууд 27500 төгрөг; дүүргийн харъяаны байгууллагууд нэг иргэнээс 14800 төгрөг авсан байна.

Үйлчилгээний хураамж төлсөн иргэдийн 34 хувь нь төлбөрийг бодитой, 39 хувь нь эргэлзээтэй, 27 хувь нь бодитой бус хэт өндөр гэж тус тус үзсэн байв.

Иргэд Нийслэл, БГД, БЗД, ЧД, СБД, ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Улсын нийгмийн даатгалын газар; СХД-ийн замын цагдаагийн тасаг; ЧД-ийн эрүүл мэндийн

нэгдэл; ЧД-ийн газрын алба; Иргэний бүртгэл мэдээллийн төв; Эд хөрөнгийн улсын бүртгэлийн төвийн иргэдээс авдаг төлбөр хураамжийг нь бодитой бус гэсэн байна.

Мөн төлбөр төлсөн иргэдийн 8 хувь нь БГД, БЗД, СБД, ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба болон Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр авдаг гэжээ.


Дээрх тоо баримтууд төрийн байгууллагуудын иргэдээс авдаг төлбөр хураамж хууль, дүрэм журамд хэр нийцэж буйг хөндлөнгийн байгууллагаар хянуулах шаардлагатай гэдгийг харуулж байна.

5.2.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй байгах дотоод нөөц, боломж ба түүний хэрэгжилт

А. Байгууллагууд иргэдэд үйлчлэх үйлчилгээний нээлттэй байдлын нөөц

Төрийн 90 байгууллагаас 74 хувьд иргэдэд үйлчлэх үйлчилгээний нээлттэй байдлыг хориглосон журам байдаггүй бол харин 18 хувьд нь зарим нэг хориг заалтууд байдаг юм байна.


График 16. Байгууллагуудад зарим үйл ажиллагаатай нь танилцахыг хориглосон дүрэм журам байдаг уу?



Дээр дурьдсан дүрэм журам байдаг байгууллагуудад Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар; СБД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; СБД-ийн засаг даргын тамгын газар; БГД, ХУД-ийн татварын хэлтэс; Нийслэл, БЗД, СХД-ийн прокурорын газар; Замын цагдаагийн газар; ЧД-ийн замын цагдаагийн тасаг; Нийслэл, СХД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар болон Хот байгуулалт, Зураг төслийн хүрээлэн ордог аж.

Мөн төрийн байгууллагуудын үйлчилгээний олон шат дамжлага иргэдийн бухимдлыг ихээр төрүүлдэг бөгөөд байгууллагуудын 29 хувь нь зарим шат дамжлагаа цөөрүүлж нэгтгэн, иргэдэд илүү түргэн шуурхай үйлчлэх боломжтой гэсэн хариулт өгсөн.

График 17. Төрийн байгууллагуудад үйлчилгээнийхээ шат дамжлагыг цөөрүүлж нэгтгэх боломж бий юү?



■ Тийм ■ Хариулахад хэцүү ■ Боломжгүй

Байгууллагууд нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх, дүрэм журмаа өөрчилж шинэчлэх, интернэтийн нэгдсэн сүлжээнд холбогдох зэрэг аргуудыг хэрэглэж шат дамжлагаа цөөрүүлэх боломж бий хэмээн тайлбарласан. Харин 62 хувь нь одоо байгаагаас илүү цөөрүүлээд байх шаардлагагүй, боломжийн түвшинд ажиллаж байна хэмээн хариулжээ.

Төрийн байгууллагуудын 35 хувь нь үйлчилгээнийхээ шат дамжлагыг цөөрүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд тодорхой арга хэмжээ авсан байна. Үүнийг байгууллагуудын үйл ажиллагааных нь чиглэлээр харьцуулж үзэхэд Татварын ерөнхий газар, хэлтэс; замын цагдаагийн газар, тасаг;

Үйлчилгээнийхээ шат дамжлагыг цөөрүүлэх тодорхой арга хэмжээ авсан байгууллагууд:

БЗД, СБД, СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; ЧД, СХД-ийн засаг даргын тамгын газар; Үндэсний татварын ерөнхий газар; Нийслэл, БГД, СБД, ХУД-ийн татварын хэлтэс; Нийслэл, БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БЗД-ийн цагдаагийн хэлтэс; БЗД, ЧД, СБД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Нийслэлийн прокурорын газар; Замын цагдаагийн газар; ЧД, СХД, ХУД-ийн замын цагдаагийн тасаг; УК-2 дугаар эмнэлэг; БЗД, СБД-ийн эрүүл мэндийн нэгдэл; Нийслэл, СБД-ийн газрын алба; Иргэний бүртгэл мэдээллийн төв; Эд хөрөнгийн, улсын бүртгэлийн төв; Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар.

Үйлчилгээнийхээ шат дамжлагыг цөөрүүлэх шаардлагагүй гэж үзсэн байгууллагууд:

Нийслэл, ЧД, ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; БГД, БЗД, ХУД-ийн засаг даргын тамгын газар; СХД-ийн татварын хэлтэс; БГД, ЧД, СБД, СХД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БГД, ЧД, СХД-ийн цагдаагийн хэлтэс; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар; БГД, СХД, ХУД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Улсын прокурорын ерөнхий газар; БГД, БЗД, ЧД, СХД-ийн прокурорын газар; БГД-ийн замын цагдаагийн тасаг; 2 дугаар төрөх газар; БГД, ЧД-ийн эрүүл мэндийн нэгдэл; БГД, ЧД, СБД-ийн газрын алба; Нийслэл, БГД, ЧД, ХУД-ийн шүүх; Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн.

Байгууллагууд ямар арга замаар үйлчилгээнийхээ шат дамжлагыг цөөрүүлж, үйлчилгээгээ иргэдэд илүү ойр болгосныг нь тодруулахад 50 хувь нь нэг цэгийн үйлчилгээг сонгон авч нэвтрүүлсэн байна.

График 18. Төрийн байгууллагуудын үйлчилгээгээ хөнгөн шуурхай болгосон арга, замууд



Б. Байгууллагын дотоод үйл ажиллагааны нээлттэй байдал

АТГ-ын зөвлөмж 12-т “Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй болгох” гэж заасан байдаг бөгөөд энэ дагуу төрийн байгууллагын ажилтнууд болон төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдээс мэдээлэл бүрдүүлсэн юм.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 88 хувьд шийдвэр гаргах үйл ажиллагаа; 82 хувьд шийдвэрийн үндэслэлтэй холбоотой мэдээлэл; 78 хувьд байгууллагын шийдвэртэй холбогдох материалууд; 56 хувьд төсвийн зарцуулалттай холбоотой мэдээлэл; 59 хувьд төсвийн зарцуулалтын үндэслэл; 48 хувьд албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг; 77 хувьд тус байгууллагын албан хаагчдын тухай болон өөр бусад мэдээллийг дотооддоо нээлттэй, ил тод байлгадаг юм байна.

График 19. Төрийн байгууллагууд АТГ-ын зөвлөмжийн дагуу явуулж буй үйл ажиллагааныхаа талаарх мэдээллээ дотооддоо нээлттэй болгож чадсан эсэх



Байгууллагууд нь дотооддоо төсвийн зарцуулалт, түүний үндэслэл болон албан тушаалтнуудынхаа хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байлгах тал дээр анхаарахгүй

байгаа нь дээрх байдлаас харагдаж байна. Үүний шалтгааныг гол төлөв хууль тогтоомжоор хязгаарласан байдагтай холбон тайлбарласан байлаа.

Мэдээллээ дотооддоо нээлттэй болгоогүй байгууллагуудын 40 хувь нь дээрх мэдээллийг 1-10 сарын дотор нээлттэй болгоно, 48 хувь нь одоогоор хариулах боломжгүй, 12 хувь буюу ЧД, СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар; СХД-ийн замын цагдаагийн тасаг; БГД, БЗД-ийн татварын хэлтэс; БГД, БЗД-ийн замын цагдаагийн тасаг; БГД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; Нийслэл, СБД-ийн шүүх болон Хот байгуулалт зураг төслийн хүрээлэн; ЧД-ийн эрүүл мэндийн нэгдэл болон ЧД-ийн шүүх боломжгүй гэсэн хариултыг тус тус өглөө. Дээрхээс үзэхэд үйл ажиллагаагаа дотооддоо нээлттэй болгох талаар төрийн байгууллагууд нааштай арга хэмжээ авч байгаа хандлага ажиглагдаж байна.

Мөн 90 байгууллагын 18 хувь нь тухайлбал БГД-ийн татварын хэлтэс; Улсын прокурорын ерөнхий газар, БЗД, ХУД-ийн замын цагдаагийн тасаг; БГД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; ХУД-ийн газрын алба; Нийслэл, СБД-ийн шүүх; болон Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн шийдвэрийн үндэслэлтэй холбоотой мэдээллээ дотооддоо хаалттай байлгадаг.

23 хувь нь байгууллагын шийдвэртэй холбогдох материалыг дотооддоо хаалттай байлгадаг бөгөөд тэдгээрт БГД, БЗД-ийн татварын хэлтэс; БГД-ийн цагдаагийн хэлтэс; ХУД-ийн замын цагдаагийн тасаг; БГД, ЧД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; ХУД-ийн газрын алба; Нийслэл, СБД-ийн шүүх; Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн багтаж байна.

44 хувьд байгууллагын төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг дотооддоо нээлттэй байлгадаггүй. Үүнд: ЧД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх газар; СБД-ийн засаг даргын тамгын газар; БГД-ийн татварын хэлтэс; БГД, БЗД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БГД-ийн цагдаагийн хэлтэс; Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Замын цагдаагийн газар; БГД, БЗД, СХД, ХУД-ийн замын цагдаагийн тасаг; ЧД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; БЗД, СБД, ХУД-ийн газрын алба; Нийслэл, СБД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар; Иргэний бүртгэл мэдээллийн төв болон Эд хөрөнгийн, улсын бүртгэлийн төв багтаж байна.

41 хувь нь байгууллагын төсвийн зарцуулалтын үндэслэлтэй холбоотой мэдээллээ дотооддоо нээлттэй болгоогүй ба үүнд ЧД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; БГД, СБД-ийн засаг даргын тамгын газар; БГД-ийн татварын хэлтэс; БГД, БЗД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; БГД-ийн цагдаагийн хэлтэс; Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Замын цагдаагийн газар; БГД, БЗД, СХД, ХУД-ийн замын цагдаагийн тасаг; УК-1-р эмнэлэг; ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; БГД, БЗД, СБД, ХУД-ийн газрын алба; Нийслэл, СБД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар орно.

52 хувь нь байгууллагынхаа албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг дотооддоо нээлттэй болгоогүй ба үүнд Нийслэл, БГД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх газар; Нийслэлийн засаг даргын тамгын газар; Үндэсний татварын ерөнхий газар; Нийслэл, БГД, БЗД, СБД, ХУД-ийн татварын хэлтэс; БГД, БЗД, ЧД, СБД, СХД, ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; ЧД, СХД-ийн цагдаагийн хэлтэс; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар; ЧД, СХД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба; Улсын прокурорын ерөнхий газар; Замын цагдаагийн газар; БГД, БЗД-ийн замыг цагдаагийн тасаг; УК-1, УК-2 дугаар эмнэлэг; СБД, СХД, ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл; БГД, СБД, СХД-ийн газрын алба; Нийслэл, БГД, СБД, ХУД-ийн шүүх; Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар; Эд хөрөнгийн улсын бүртгэлийн төв; Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн тус тус багтаж байна.

5.2.3 Төрийн байгууллага үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангах дотоод нөөц боломж ба түүний хэрэгжилт

Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 41 хувь нь иргэдэд үйлчилгээ үзүүлэх явцад иргэдээс гомдол ихээр, 43 хувь нь хааяа гаргадаг, харин 12 хувь нь гаргадаггүй гэсэн хариулт тус тус өгсөн бөгөөд шүүх, прокурорын байгууллагуудад гомдол илүү ирдэг байна.

График 20. Төрийн байгууллагуудад иргэдээс гомдол хэр ирдэг вэ?




Хүснэгт 6. Төрийн байгууллагуудад иргэдээс гомдол хэр их ирдэг вэ? Байгууллагуудын чиг үүргээр /хувь/

	Ер нь их гардаг	Хааяа гардаг	Ер гардаггүй
Шүүхийн шийдвэр газар, алба	87.5	-	12.5
Засаг даргын тамгын газар	14.3	71.4	14.3
Татварын газар, хэлтэс	-	50.0	37.5
Нийгмийн даатгалын газар, хэлтэс	62.5	25.0	-
Цагдаагийн газар, хэлтэс	50.0	50.0	-
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, алба	25.0	50.0	25.0
Прокурорын газар	66.7	33.3	-
Замын цагдаагийн газар	50.0	16.7	16.7
Эмнэлэг	33.3	66.7	-
Газрын алба	42.9	57.1	-
Шүүх	42.9	57.1	-
Засгийн газрын агентлаг	20.0	40.0	40.0

22 хувьд иргэдийн өргөдөл, санал, гомдол хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдэж амждаггүй бөгөөд ялангуяа дүүргийн болон анхан шатны байгууллагуудад энэ зөрчил их хэмжээгээр гардаг юм байна.

График 21. Төрийн байгууллагуудад иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж амжихгүй байх тохиолдол гардаг уу?




Удирдлагын олон шат дамжлага; ажлын уялдаа холбоо муу, хууль дүрэмд засан хугацаа зарим тохиолдолд богино байдаг; төлбөр төлөгчийн санхүүгийн хүндрэл; ажлын

ачаалал их, байгууллагуудын санхүүгийн хүндрэл, иргэд бичиг баримт дутуу бөглүүлж ирдэг; ажилтнуудын ёс зүйгээ хэрхэн сахиж байгаа, хариуцлагагүй байдал болон мөн шийдвэрлэж буй тухайн асуудлын онцлог зэрэг хүчин зүйлээс тус тус шалтгаалж иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж амжихгүй байх тохиолдлууд гардаг ажээ.

АТГ-ын зөвлөмжийн 16-р зүйлд “Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох” гэж заасныг төрийн байгууллагуудад үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг эсэхийг 8 дугаар сард хийсэн судалгаанаас үзэхэд 47 хувь нь олон нийтийн саналыг авдаг юм байна. Харин 10 дугаар сард 43 хувь болж буурсан байна.

График 22. Төрийн байгууллагууд тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авдаг уу?



Цагдаагийн газар, хэлтэс; Нийгмийн даатгалын газар, хэлтэс; Прокурорын газар; Газрын алба зэрэг байгууллагуудын 68-иас дээш хувь нь тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг авдаггүй ба шүүх; Замын цагдаагийн газар, тасаг; Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагууд иргэдийн саналыг авах шаардлагагүй гэсэн хариулт тус тус өгсөн байна.

Хүснэгт 7. Төрийн байгууллагууд олон нийтийн санал бодлыг авдаг уу? Байгууллагын чиг үүргээр /хувь/

	Авдаг	Авдаггүй	Шаардлагагүй
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба	62.5	37.5	-
Засаг даргын тамгын газар	71.4	-	28.6
Татварын газар, хэлтэс	50.0	37.5	12.5
Нийгмийн даатгалын газар, хэлтэс	25.0	75.0	-
Цагдаагийн газар, хэлтэс	-	100.0	-
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, алба	87.5	12.5	-
Прокурорын газар	16.7	66.7	16.7
Замын цагдаагийн газар	50.0	16.7	33.3
Эмнэлэг	66.7	22.2	11.1
Газрын алба	28.6	71.4	-
Шүүх	14.3	28.6	57.1
Засгийн газрын агентлаг	60.0	40.0	-

Иргэдийн саналыг авдаг гэсэн мэдээлэл өгсөн 28 байгууллагын 23 хувь нь хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулахдаа; 5 хувь нь дотоод дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулахдаа, 18 хувь нь тухайн байгууллагад хандсан иргэдийн асуудлыг

шийдвэрлэхдээ, 37 хувь нь үйлчилгээнийхээ талаар, 18 хувь нь бусад асуудлаар иргэдийн санал бодлыг тус тус авч байжээ.

Иргэдийн саналыг авдаг байгууллагуудын 72 хувь нь албан бичгээр, 63 хувь нь санал гомдол хүлээн авах ажилтнаар дамжуулж, мөн 63 хувь нь иргэдээс мэдээлэл авах утас ашиглах аргаар санал авдаг гэжээ.

Иргэдийн саналыг авдаггүй 35 байгууллага, байгууллагын онцлог, хууль тогтоомж, дээд шатны болон удирдлагын зүгээс зөвхөн хуульд заасны дагуу шийдвэр гаргадаг хатуу шаталсан тогтолцоотой байдаг зэргээс шалтгаалдаг гэсэн тайлбарыг хийсэн байна.

График 23. Төрийн байгууллагуудын иргэдээс санал хүлээн авах хэлбэрүүд



Байгууллагууд үйл ажиллагааныхаа онцлогоос шалтгаалан иргэдийн санал, гомдлыг авах арга хэлбэр нь харилцан адилгүй байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба мэдээлэл хүлээн авах утас ба албан бичгээр мэдээлэл авах хэлбэрийг түлхүү ашиглаж байхад эмнэлгүүд санал хүсэлтийн хайрцаг, засгийн газрын агентлагууд ихэвчлэн албан бичгээр авч байна.


Хүснэгт 8. Төрийн байгууллагуудын иргэдээс санал хүлээн авах хэлбэрүүд Байгууллагын чиг үүргээр /хувь/

	Санал хүсэлтийн хайрцаг	Санал хүсэлтийн дэвтэр	Мэдээлэл авах утас	Интернет шуудан	Хүлээн авах ажилтан	Албан бичиг г.м	Өөрөө уулздаг
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, алба	12.5	37.5	100.0	87.5	87.5	100.0	75.0
Засаг даргын тамгын газар	14.3	28.6	57.1	14.3	57.1	57.1	28.6
Татварын газар, алба	62.5	37.5	50.0	37.5	62.5	87.5	37.5
Нийгмийн даатгалын газар, алба	50.0	50.0	75.0	12.5	62.5	62.5	62.5
Цагдаагийн газар, хэлтэс	75.0	25.0	50.0	-	50.0	50.0	25.0
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, алба	75.0	75.0	62.5	25.0	37.5	62.5	50.0
Прокурорын газар	-	-	16.7	-	66.7	83.3	66.7
Замын цагдаагийн газар	83.3	66.7	83.3	33.3	83.3	83.3	50.0
Эмнэлэг	100.0	77.8	88.9	55.6	77.8	66.7	55.6
Газрын алба	85.7	28.6	42.9	-	42.9	42.9	42.9
Шүүх	28.6	-	28.6	14.3	57.1	71.4	14.3
Засгийн газрын Агентлаг	80.0	20.0	80.0	80.0	60.0	100.0	60.0

АТГ-ын зөвлөмжийн 3 дахь бүлэгт төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлэх талаар заасан бөгөөд уг заалтыг хэрэгжүүлэх механизм байгууллагуудад бий эсэхийг тандсан тандалтын үр дүнг тайлангийн энэ хэсэгт орууллаа.

Судалгаанд хамрагдсан төрийн нийт 81 байгууллагын 63 хувь нь иргэдээс санал, гомдол хүлээн авах утас ажиллуулдаг гэжээ. Гэтэл үйлчлүүлэгч иргэдийн 4 хувь нь л үүнийг мэдэж байсан бөгөөд тэднээс 6 хувь нь тус утсыг ашиглаж байжээ.

График 24. Төрийн байгууллагуудаас үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангаж буй байдал.



Мөн байгууллагуудын 63 хувь нь иргэдийн санал, гомдол хүлээн авах ажилтантай гэсэн бол харин иргэдийн 26 хувь нь энэ талаар мэдэж байсан. Түүнчлэн, санал, хүсэлтийн хайрцаг, интернет шуудан зэрэг мэдээлэл түгээх бусад хэлбэрийн ашиглалт мөн адил хангалтгүй байлаа.

Судалгаанд оролцсон 430 үйлчлүүлэгчийн 33 хувь нь урьд өмнө нь тухайн байгууллагад гомдол гаргаж байжээ. Эдгээр 142 иргэний 13 хувь нь асуудлаа шуурхай шийдвэрлүүлж чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарсан, 52 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байсан зэрэг нь төрийн байгууллагуудын иргэдийн оролцоог хангах механизм ихээхэн доголдолтой байдгийг харуулж байна.

АТГ-ын зөвлөмжийн 14 дугаарт “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх” хэмээн заасан байдаг. Гэтэл 8 дугаар сард хийсэн судалгаанаас харахад нийт 319 иргэний 5 хувь нь тухайн байгууллагад нэвтэрч чадаагүй ба харин 10 дугаар сард 430 иргэний 2 хувь хориг саадтай учирчээ.

БЗД, СХД, ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба; Нийслэлийн засаг даргын тамгын газар; БГД-ийн нийгмийн даатгалын хэлтэс; Улсын цагдаагийн ерөнхий газар; ЧД, СБД, ХУД-ийн цагдаагийн хэлтэс; Нийслэлийн прокурорын газар; Замын цагдаагийн газар; БЗД, ЧД, СХД-ийн замын цагдаагийн тасаг; БЗД-ийн газрын алба; Улсын дээд шүүх; БЗД, СБД, СХД-ийн шүүх зэрэг байгууллагуудыг иргэд нэвтрэхэд саадтай байгууллагын тоонд оруулж болно.

АТГ зөвлөмждөө шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах талаар тусгасан байдаг ба энэ талаар судалж үзэхэд байгууллагууд маш хангалтгүй үзүүлэлттэй байлаа. Тухайлбал, 8 дугаар сарын мониторингийн үр дүнгээс харахад 107 байгууллагын 51 хувь нь бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө иргэдээс санал авдаг гэж хариулсан бол 10 дугаар сард үйлчлүүлэгч 430 иргэний 4 хувь нь л тийм гэсэн хариулт өгч байлаа. Харин 9 хувь нь авдаггүй, дийлэнх нь /88 хувь/ энэ тухай мэдэхгүй байсан.


Үйлчлүүлэгч иргэдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох чирэгдлийг багасгах, түгээж буй мэдээллээ байнга шинэчилж байх, үйлчилгээнийхээ зохион байгуулалтыг сайжруулах авлигатай тэмцэх, иргэдэд хүрч ажиллах, албан хаагчдынхаа харилцааны соёл, ёс зүйд анхаарах зэрэг саналуудыг тавьж байлаа.

Зургаа. Иргэдээс санал, гомдол хүлээн авах 1977 шууд утасны мэдээлэл

Төслийн хүрээнд төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаарх санал, гомдлыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ шууд утсыг нээлттэй ажиллууллаа. Утсаар ирсэн мэдээллийг судлан үзэж, АТГ-аас тухайн байгууллагын удирдлагад үйл ажиллагаандаа гаргасан зөрчлөө нэн даруй арилгах арга хэмжээ авч, эргэж мэдээлэхийг сануулсан шаардлага хүргүүлэн ажилласан болно. Харин төслийн хугацаанаас хамаарч тайланд 11 дүгээр сарын 30-ныг хүртэлх 5 сарын утасны мэдээллийг багцалж оруулав.

Өнгөрсөн 5 сарын хугацаанд 1977 утсаар иргэдээс нийт 330 гомдол ирүүлсэн байна. 7 дугаар сард зуны улирлын амралт эхэлдэг тул санал, гомдлын тоо харьцангуй бага байлаа. Харин 8 дугаар сараас эхлэн иргэдээс ирүүлсэн санал гомдлын тоо дахин нэмэгдсэн ч 11 дугаар сард АТГ нь авлигын гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл хүлээн авах 1969 утас ажиллуулж, 1977 утасны сурталчилгаагаа зогсоосон нь төрийн байгууллагын албан хаагчдын хүнд суртлын талаархи иргэдийн санал, гомдлын тоо цөөрөхөд нөлөөлсөн хэмээн үзэж байна.

График 25. 1977 утсаар ирсэн санал, гомдлын сар бүрийн хэмжээ /хувиар/



Иргэдийн санал, гомдлыг долоо хоног бүрийн лхагва, баасан гарагуудад АТГ-т хүргүүлж байв.

1977 утсанд хандсан 330 иргэний 91 хувь нь Улаанбаатар хотоос, 11 хувь нь хөдөө орон нутгаас холбогдож байсан нь энэхүү үйл ажиллагаа үр дүнгээ өгсөн нь харагдаж байна.

330 иргэний 31 хувь урьд өмнө нь тухайлсан байгууллага албан тушаалтанд хандаж байжээ. Тэдний 88 хувь нь өмнөхтэйгөө ижил, 12 хувь нь өөр бусад асуудал шийдвэрлүүлэх зорилготой байсан бөгөөд зохих журмын дагуу хандсан ч дөнгөж 3 хувь нь асуудлаа шийдвэрлүүлж чаджээ. Энэ нь төрийн байгууллагад иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх механизм бараг байхгүй байна гэсэн үг юм.


График 26. Иргэдийн өмнө нь гаргасан гомдлыг шийдвэрлэж өгөөгүй байгууллагууд



6.1 Үйл ажиллагаандаа зөрчил гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн байгууллагуудын тухай мэдээлэл

Хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах эрх хэмжээгээр нь авч үзвэл харьцангуй их буюу 45 хувийг дүүрэг, сумын; 26 хувийг улсын хэмжээний; 21 хувийг аймаг, нийслэлийн хэмжээний; 8 хувийг баг, хорооны байгууллагууд тус тус эзэлж байв.

График 27. Иргэдийг чирэгдүүлж, зөрчил гаргасан байгууллагууд Үйл ажиллагааны эрх хэмжээгээр



Анхан шатны байгууллагууд иргэдийг ихээр чирэгдүүлж байна.

Байгууллагуудыг үйл ажиллагааных нь чиглэлээр харьцуулбал иргэд газрын албаны зөрчилтэй үйл ажиллагааны талаар бусад байгууллагынхаас хоёр дахин илүү гомдол гаргажээ. Түүнчлэн Засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн газар, эмнэлэг, Шүүхийн шийдвэр биелүүлэх газрууд эхний 5-д орж байна.

**График 28. Иргэдийг чирэгдүүлж зөрчил гаргасан байгууллагууд
Үйл ажиллагааны чиг үүргээр**



6.2 Албан тушаалтны тухай мэдээлэл

Иргэдийн гаргасан гомдлоос үзвэл газрын албаны байцаагч, шүүгч, иргэний бүртгэл мэдээллийн ажилтан зэрэг төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан; цагдаагийн байгууллагын албан тушаалтан, мөрдөн байцаагчид, зэвсэгт хүчний байгууллагын албан тушаалтнууд зэрэг төрийн тусгай байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан; төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дунд шатны дарга нар хүнд суртал ихтэй байгаа нь ажиглагдлаа.

График 29. Иргэдийг чирэгдүүлж буй төрийн байгууллагын ажилтнууд




Үйл ажиллагааны чиглэлээрээ газрын албаны гүйцэтгэх албан тушаалын байцаагч нар /20 хувь/; замын цагдаагийн газрын гүйцэтгэх албан тушаалтнууд /7 хувь/; эмч, сувилагчид /5 хувь/; сум, дүүргийн засаг дарга зэрэг улс төрийн анхан шатны удирдах албан тушаалтнуудын дийлэнх нь үүнд багтаж байв.

6.3 Иргэдийн төрийн байгууллагад хандсан зорилго

Утсаар холбогдсон иргэд газар эзэмших эрхийн бичиг авах /13 хувь/; шүүхээс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх /10 хувь/; аюулгүй амьдрах орчноо баталгаажуулах /9 хувь/; бичиг баримт бүрдүүлэх, авах /8 хувь/; тодорхойлолт авах /6 хувь/; эмнэлгийн үйлчилгээ хүртэх /6 хувь/ зорилгоор төрийн байгууллагуудад тус тус хандсан боловч асуудлыг нь шийдвэрлэж өгөөгүй байна.

График 30. Иргэдийн төрийн байгууллагуудад хандсан зорилго



6.4 Гомдол гаргасан үндэслэл

Төрийн байгууллагуудаад чиг үүрэгтээ хамаарах асуудлыг шийдвэрлэхээс зайлсхийх; хуульд заасан хугацаанд шийдвэрлэхгүй байх зэрэг зөрчлүүд ихээр гарч байв. Түүнчлэн албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, хувийн ашиг хонжоо олох, үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр авах, ажил үүргээ мэдэхгүйгээс хариуцлагагүй хандах зэргээр иргэдийг хохироосон нь тэдний гомдол гаргах үндэслэл болжээ.


График 31. Иргэдийн гомдол гаргасан үндэслэл



6.5 Асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулсан хугацаа

Утсаар холбогдсон иргэдийн үнэмлэхүй хувь нь /65 хувь/ гомдол гаргасан байгууллагадаа хандаад 1 сараас 2 жил, түүнээс дээш хугацаа өнгөрч байна гэжээ. Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулж байгаа хугацааг тодорхой интервалуудад хувааж үзэхэд 35 хувь нь 1 хүртлэх сар болж байгаа, 21 хувь нь 7 сараас нэг жил, 17 хувь нь 4-өөс 6 сар, мөн 12 хувь нь 2-оос дээш жил тус тус болж байна.

График 32. Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулсан хугацаа



Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулж байгаа хугацааг байгууллагуудын эрх хэмжээгээр харьцуулж харуулав.

**Хүснэгт 9. Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхээр зарцуулж байгаа хугацаа
Байгууллагын эрх хэмжээгээр /хувь/**

Хугацаа	Улс	Нийслэл, аймаг	Дүүрэг, сум	Хороо, баг	Нийт
Нэг сар болоогүй	7.9	5.1	17.1	5.1	35.2
1-3 сар	3.8	2.5	2.5	0.3	9.2
4-6 сар	6.3	4.1	5.1	1.3	16.8
7 сараас нэг жил	6.3	4.4	8.6	1.3	20.6
1-ээс 2 жил	0.3	1.9	3.8	-	6.0
2-оос дээш жил	1.6	3.8	6.7	-	12.1
Нийт	26.3	21.9	43.8	7.9	100.0

Баг, хороо зэрэг төрийн анхан шатны байгууллагууд иргэдийн асуудлыг шийдвэрлэхгүй удаах хандлага бага байдаг бол дүүрэг, сумын хэмжээний байгууллагуудад энэ зөрчил түгээмэл байсан.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр харьцуулбал газрын албад болон засаг даргын тамгын газрууд иргэдийг хамгийн ихээр чирэгдүүлдэг байна.

Иргэдийн саналын тухай мэдээлэл

Иргэд төрийн 18 албан байгууллага, албан тушаалтнуудад 1977 утсаар дамжуулан хандаж санал ирүүлсэн ба тэдний 16 нь Улаанбаатар хотоос холбогдсон байна. Мөн 8 иргэн АТГ-т хандаж тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянуулах санал гаргасан нь олон нийтийн зүгээс АТГ-т итгэл үзүүлэн найдвар тавьж байгааг харуулж байна.

Иргэдийн өгсөн саналуудыг дор дурьдвал:

Санал 1. АТГ-т: “Монгол улсын бүх ашигт малтмал гадаадад гараад дууслаа, үүнд маш ихээр санаа зовж байна. Та бүхэн миний бичсэн номын мөрөөр мөшгөвөл маш чухал мэдээллүүдийг олж авна шүү”

Санал 2. АТГ-т: “Орос улсын хилээр өндөр үнэтэй бараа орж ирэхэд тэр хэмжээний гаалийн татвар төлдөг ба гаалийн бүрдүүлэлт нь ч нарийн байдаг. Харин манай улсын хил гааль дээр Орос улсын гаальд төлсөн бичгээ нууж татвар төлдөг. Иймд Орос улсын гаалийн бүрдүүлэлттэй тулгалт хийдэг болговол зүгээр байна. Боломжтой бол танай байгууллага хүн томилж ажиллуулдаг”

Санал 3. АТГ-т: “Хуурай мухар” зусланд төрийн өмчийн хорооны дарга Сугар, орлогч Сүхбаатар нар их хэмжээний газар эзэмшээд зогсохгүй, асар том байшин бариулж байна. Үүнийг шалгаж өгөөч”

Санал 4. Нийслэлийн газрын албаны зохих албан тушаалтнуудад: “Манай байрны урд 2006 оны хавраас эхлэн барилга баригдаж эхэлсэн бөгөөд оршин суугчид энэ тухай асууж лавлахад “граж” гэсэн хариултыг өгсөн. Яваандаа граж нь 5 давхар барилга болж хэмжээ нь томорсон. Бид холбогдох байгууллагуудад хандсан боловч ямар нэгэн хариу ирүүлээгүй болно. Одоо энэ байшиндаа иргэдээс захиалга авч эхлээд байна. Хаанаас, зөвшөөрөлтэй, хэний мэдлийн барилга болохыг шалгаж өгнө үү”

Санал 5. Монгол Улсын Засгийн Газар болон Сангийн яаманд: “Таван толгой, Оюу толгойн гэрээнд анхаарал хандуулж ажиллаач. Хууль тогтоомжийн хүрээнд ямар гэрээ хэлэлцээр

хийх нь манай засгийн газар, манай улсын эрх хэмжээний асуудал. Канадын хэсэг хүмүүс ирж засгийн газарт шаардлага тавин, дээрх уурхайнуудад ажиллаж байгаа ажилчдаар “Эрх чөлөөний талбай”-д жагсаал цуглаан хийлгэж байгаа нь Монгол улсын хууль дүрэмд хэр нийцтэй вэ? Гэрээг луйврын аргаар бус зөвхөн хуулийн дагуу хийгээч. Үүнд АТГ-ын хяналт, шалгалт маш их хэрэгтэй байна”

Санал 6. АТГ-ын зохих албан тушаалтнуудад: “Хуулиндаа өөрчлөлт оруулмаар байна. Монголд ажиллаж байгаа хятад иргэдийн визний хугацаа дууссаныг мэдэгдэж цагдаагийн байгууллагад хандахад цагдаа нар тэдэнтэй үгсэн хуйвалдаад явуулчих юм”

Санал 7. АТГ-ын албан тушаалтан, ажилнуудад “Авлига авсан гэж квитанц бичиж өгдөггүй болохоор авлига өгөх, авах хэрэг илэрнэ гэж байхгүй. Иймд доорх 2 арга хэрэглэвэл ямар вэ: 1-рт, Авлига өгсөн этгээдийг шийтгэдэггүй байх талаар хуульдаа нэмэлт заалт оруулах. Гадаадын улс орнуудад ийм заалт хуулиндаа оруулсны дараа авлига 50 хувь буурсан баримт бий. 2-рт, АТГ-ын ажилтан, албан тушаалтнууд зориудаар авлига өгч шалгаж байна гэсэн сенсаци дэгдээвэл хүмүүс авлига авахгүй байх болов уу ”

Санал 8. Улсын Мэргэжлийн Хяналтын газрын байгаль орчны улсын байцаагчдад “Чингэлтэй дүүргийн 4-р хорооны 6-р байрны урд хүүхдийн тоглоомын талбай дээр газар ухаж байна. Энэ тухай асууж лавлахад 5 давхар оффис баригдах гэж байгаа гэнэ. Нийслэлийн Засаг дарга Энхболдын гарын үсэгтэй зөвшөөрөл үзүүлээ. 2004 онд батлагдсан уг захирамжийн дагуу иргэн Далайд 5 жилийн хугацаатай уг газрыг эзэмшүүлсэн байв. Улсын Мэргэжлийн Хяналтын Газарын байгаль орчны улсын хяналтын байцаагч Энхчимэг уг талбай дээр барилга бариулахыг зөвшөөрсөн байна. Ер нь хүүхдийн тоглоомын талбайд барилга бариулахгүй байж болдоггүй юм уу. Хүүхэд тоглох орчингүй боллоо”

Санал 9. СХД-ын татварын хэлтэс, санхүүгийн тасгийн холбогдох албан тушаалтан, дарга нарт: “Сарын сүүлээр татварын албанд тайлангаа өгөхөд эхлээд СХД-ын санхүүгийн тасгаар батлуул гэдэг. СХД-ын санхүүгийн тасаг дээр очиход ажилтан нь их удаан хүлээлгэж чирэгдүүлдэг. Сар болгоны сүүлээр санхүүгийн албаны ажилтныг ажлаас нь хэсэг хугацаанд бүрэн чөлөөлж суулгадаг гэх боловч нөгөөх ажилтан нь би ажилтай гээд явчихдаг. Хойноос нь уулзах гээд очиход олддоггүй. Чирэгдэлтэй байна. 1-рт, Татварын албаны байранд 3-4 өрөө гаргаж санхүүгийн тасгийг оруулж өгөх; 2-рт, Татварын хэлтэст ажиллаж байгаа санхүүгийн хэлтсийн ажилтныг 7 хоногийн хугацаанд ажлаас нь бүрэн чөлөөлж, байгууллагуудын тайланг хүлээж авдаг болговол зүгээр юм”

Санал 10. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр гаргадаг эрх бүхий албан тушаалтнуудад хандаж “Төрийн албан хаагчид ажлаа хийдэггүй, ажлын цагаар гадуур ажилтай гэх нэрийдлээр хувийнхаа ажлыг гүйцэлдүүлж явдаг. Мөн байгууллагуудын иргэдийг хүлээн авдаг өдөр 7 хоногт 2-3 байгаа нь хангалтгүй байна. Төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбогдуулж ажлын өдрийг 6 болгож нэмж өгөөч”

Санал 11. Монголын Цахилгаан Холбоо компанийн холбогдох албан тушаалтнуудад хандаж: “Энгийн утасны төлбөрийн тооцоо сар бүрийн 5-6 өдрүүдэд гардаг бөгөөд сар дуусаагүй байхад утас тасалдаг. Сар бүр 2000–оос 3000 төгрөгийн төлбөр төлдөг айл өрхүүдэд энэ нь хүндрэлтэй байх юм. Энэ асуудал дээр анхаарч ажиллана уу”

Санал 12. Авлигатай Тэмцэх Газарын холбогдох албан тушаалтнуудад хандаж “Газрын албадын ажлыг сайжруулж, газар давхар олгох асуудлыг таслан зогсоох. Мөн АТГ-аас өөрийн вэб хуудсанд газрын албад болон бусад байгууллагуудын хүнд суртлыг хэрхэн багасгавал зохистойг иргэдээс асууж, саналыг нь авах”

Санал 13. АТГ-ын холбогдох албан тушаалтнуудад хандаж “Баянзүрх дүүргийн “East” худалдааны төвд байрлах бар өглөө 07 цаг хүртэл ажиллаж согтууруулах ундаагаар үйлчилдэг. Энэ талаар дүүргийн цагдаагийн хэлтэс, ЗДТГ-т мэдээлсэн боловч уг барны эзэн нь том албан тушаал эрхэлдэг учир хаах боломжгүй гэсэн хариултыг өгсөн. Энэ асуудлыг нягтлан шалгаж өгнө үү”

Санал 14. Дорноговь аймгийн татварын хэлтсийн байцаагч нарт “Дорноговь аймагт хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд үйл ажиллагаагаа явуулах патент өгдөг. Харин үсчингүүдээс орлогын албан татварыг 10 хувиар тооцож авдаг. Үсчингүүдэд адилхан патент өгч болдоггүй юм уу”

Санал 15. АТГ-ын холбогдох албан тушаалтнуудад хандаж “АМГТХЭГ-ын Тамгын Газрын дарга Дэлгэрдалай тус газрын хууль зүйн хэлтсээс гаргасан дүгнэлтийг дур мэдэн өөрчилж, өөрийн санааг оруулж баталгаажуулдаг. Түүний баталгаажуулсан бичиг баримтын талаар лавлан асуухад би гарын үсэг зураагүй хэмээн булзааруулдаг. Ашигт малтмалын тухай зөвшөөрлын лицензийг байгууллагын дотоод хяналтаар оруулан аль болох цуцлах талаар арга хэмжээ авч, өө сэв хайдаг. Энэ хүнийг албан тушаалаас нь түдгэлзүүлж байгаад шалгавал илүү ноцтой баримтууд гарч ирнэ. Архиваас Дэлгэрмаагийн гарын үсэгтэй бүх материалыг шалгаж өгөөч”

Санал 16. АТГ-ын холбогдох албан тушаалтнуудын “Сонгино Хангай” ХХК нь өнгөрсөн хугацаанд 2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Харин үүнээс СХД-ийн татварын хэлтэст зөвхөн 300 сая төгрөгийн татвар төлжээ. Энд СХД-ын ажилтнуудын авлига авсан гэж үзэж байна. Та бүхэн СХД-ийн Татварын хэлтсийг шалгаж өгнө үү”/Үүнийг нотлох баримт бий/

Санал 17. СХД-ийн замын цагдаагийн тасгийн техник, тоо бүртгэлийн ажилтнуудад “Тус замын цагдаагийн тасаг нь иргэдийг зөвхөн 09.30-аас 12.30 цагийн хооронд хүлээн аваад бусад үед баримт материал дээрээ ажилладаг нь иргэдийг хүлээлгэж, чирэгдүүлж байна. Иймээс иргэдийг хүлээн авах цагийг нь уртасгах хэрэгтэй. Ажлын цаг амьдралаас тасархай, ийм уялдаа холбоогүй байж болохгүй”

Санал 18. “Хэвлэл мэдээллийн байгууллагаар, ялангуяа радио, телевизээр санал бодлоо хэлэх, хэвлэн нийтлэх гэхээр авлига авсан хүнийхийг хүлээж авдаг юм байна. Эсвэл олны танил нэртэй хүмүүсийн материалыг хэвлэх, ярилцлагад оруулдаг. Харин жирийн иргэдээс заавал гар хардаг. Энэ байдлыг нь болиулах арга хэмжээ авч өгөөч. Үүнийг яаж таслан зогсоох вэ”

Долоо. Дүгнэлт, зөвлөмж

7.1 Дүгнэлт

7.1.1. Ерөнхий дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын 41 хувь нь л АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Харин 12 хувь нь зөвлөмжийг судлах шатандаа байгаа бол 34 хувь нь зөвхөн тойм мэдээлэл авсан төдий, 13 хувь нь энэ тухай мэдээлэлгүй байв. Энэ нь нэг талаар АТГ-аас 4-р сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтэнд тавьсан хяналт сул байсан, нөгөөтэйгүүр байгууллагын үйл ажиллагааныхаа талаарх танилцуулгыг хангалттай хийгээгүй зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.
- АТГ нь сүүлийн саруудад үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хяналтаа сайжруулсантай холбоотойгоор төрийн байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл явцын идэвх сайжрах хандлага ажиглагдсан нь нааштай үзүүлэлт юм.
- Төрийн байгууллагууд 8 дугаар сараас хойш АТГ-ын зөвлөмжийн талаар мэдээлэл авч, судалж эхэлсэн, мөн хэрэгжүүлэх шатандаа орсон нь мониторингийн судалгаа хийсэн болон 1977 утасны сурталчилгааг эрчимжүүлсэнтэй холбоотой.
- АТГ нь шинээр байгуулагдаад удаагүй байгаа байгууллага тул иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулж байх зайлшгүй шаардлагатай байна. Үүний нэг жишээ нь 11 дүгээр сард 1977 утасны сурталчилгааг зогсоосон нь иргэдээс ирж байсан санал, гомдлын тоо цөөрөхөд шууд нөлөөлсөн явдал юм.

7.1.2. Мэдээлэл хүртээмжтэй байх талаар

- Мэдээллийг хүртээмжтэй байлгах хэлбэрүүд, түүний ашиглалт төрийн байгууллагад харилцан адилгүй байна. Олонх байгууллагад иргэдэд мэдээлэл түгээх самбар, мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан байгаа бол, харин вэб сайт, тараах материал хангалтгүй байлаа. Үүний шалтгааныг төсөв санхүүгийн хүндрэл болон иргэд мэдээлэл түгээх дээрх хэлбэрүүдийг тэр бүр ашигладаггүйтэй холбон тайлбарлаж байв. Вэб сайттай байгууллагууд сайт дахь мэдээллийн агуулгаа шинэчлэх тал дээр муу үзүүлэлттэй байна.
- Судалгаанд хамрагдсан 90 байгууллагын талаас илүү хувьд нь иргэдийн гомдол, санлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм байдаг ч гаргасан зөрчлийг арилгах тал дээр тун сул ажиллаж байна. Мониторингийн судалгаа хийх явцад үйлчлүүлж байсан нийт 430 иргэний 33 хувь нь гомдол гаргаж, тэднээс дөнгөж 13 хувь нь асуудлаа шуурхай шийдвэрлүүлж

чадсан бол 35 хувь нь шийдвэрлүүлэх явцдаа хүнд сурталтай тулгарсан, 52 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байна.

- Төрийн зарим байгууллагууд үндэслэлгүйгээр төлбөр хураамж авч байна хэмээн үйлчлүүлэгч иргэд үзэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, судалгаанд оролцсон иргэдийн 18 хувь нь дунджаар хорь гаруй мянган төгрөгийн хураамж төлсөн байв. Төрийн байгууллагуудын, иргэдээс авч буй төлбөр хураамжийн хувь хэмжээ, авч буй үндэслэл нь эргэлзээтэй байна.
- Төрийн байгууллагууд нь дотооддоо төсвийн зарцуулалт болон албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй байлгах тал дээр сул ажиллаж байна. Үүний шалтгааныг гол төлөв хууль, дүрэм журмаар хязгаарласан байдагтай холбон тайлбарлаж байлаа. Гэтэл тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудыг судалж үзэхэд ийм заалт байхгүй байв. Байгууллагууд дотоод дүрэм журмаа Монгол улсын үндсэн хууль болон бусад хуульд харшлахгүйгээр боловсруулан, үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор өөрчилж болох атал энэ тал дээр дэвшилттэй алхам хийсэн нь тун цөөн байгаа бөгөөд эндээс төрийн байгууллагууд бүхэлдээ хүнд сурталд автжээ гэсэн дүгнэлтийг хийж байна.
- Байгууллагууд иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа тавьж, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх тал дээр хангалтгүй ажиллаж байна. Мэдээлэл түгээх самбар, мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан зэрэг бусад мэдээллийн хэлбэрүүд түгээмэл байдаг нь үйлчлүүлэгч иргэдээс авсан сурвалжилга, ажиглалт, бичиг баримтын судалгаануудаас тодорхой харагдаж байна.

7.1.3. Үйл ажиллагаагаа нээлттэй байлгах талаар

- Хүнд суртал, чирэгдэл ихтэй, иргэдийн шийдвэрлүүлэхээр хандсан асуудлыг хуульд заасан хугацаанаас нь сунжруулах явдал түгээмэл байна. Ийм зөрчилтэй байгууллагуудыг Газрын албад, Засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албад тэргүүлж байв.
- Судалгаанд оролцсон төрийн байгууллагуудын албан хаагчид тухайн байгууллагын шийдвэр гаргах үйл явц нь дотооддоо нээлттэй байдаг гэсэн болов, харин судалгаанд иргэдийн өгсөн мэдээллээс үзэхэд зөвлөмжид заасанчлан түүний үндэслэлийн талаархи мэдээлэл иргэд, хуулийн этгээдэд нээлттэй байж чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь энэ чиглэлийн ажил төрийн байгууллагуудад хэвшил болоогүйтэй холбоотой гэж дүгнэж болох юм.

7.1.4. Үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлэх

- Хэдийгээр төрийн байгууллагуудад иргэдээс санал, гомдол хүлээн авах утас, санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, тусгай ажилтан ажиллуулах зэрэг боломж байгаа ч санал гомдлыг хүлээн авах, барагдуулах механизм хангалтгүй ажиллаж байна. Үүнд, нэг талаас санал, гомдлыг хүлээн авах арга хэлбэрээ иргэдэд танилцуулдаггүйгээс тэд мэддэггүй, үүнээс шалтгаалж байгууллагуудад хандаж санал гомдол гаргахгүй байх нь элбэг, нөгөөтэйгүүр төрийн байгууллагуудад итгэх итгэл үлэмж алдарсан нь нөлөөлж байна.
- Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн саналыг авах, талаар төрийн байгууллагууд хангалтгүй ажиллаж байна.
- Байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд мэдээлэх ажиллагаа төрийн байгууллагуудад сул байна.

7.2 Зөвлөмж

- АТГ нь үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд сайтар танилцуулж, зорилтот бүлгээ зөв сонгон, агуулга хэлбэрийг сайтар бодож боловсруулан, оновчтой хэрэгслээр дамжуулан цаашид тогтмол явуулах нь зүйтэй.
- АТГ нь төрийн байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтэд тавих хяналтаа сайжруулах шаардлагатай байна.
- Төрийн байгууллагуудад урьд өмнө нь огт байгаагүй болон чиг үүргээс нь гадуурхи үйл ажиллагаа явуулахыг шаардсан зүйл заалтууд АТГ-ын зөвлөмжид байхгүй бөгөөд уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах суурь нөөц боломж хангалттай бүрдсэн байна гэж үзэж байна. Зөвлөмж хэрэгжихгүй байгаад анхаарлаа түлхүү хандуулж, хариуцлагад тооцох механизмыг ажиллуулдаг болгоход нөлөөлөх нь зүйтэй.

7.2.1 Зөвлөмжийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд:

- АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхийг төрийн байгууллагуудад хянан хариуцах үүрэгтэй тусгай ажилтан, эсвэл ажил үүрэг нь ижил бүтцэд албан ёсоор даалган хариуцуулах шаардлагатай байна.
- АТГ нь 3 бүлэг 18 заалт бүхий зөвлөмжөө цаашид үйл ажиллагаатайгаа уялдуулж, боловсронгуй болгон сайжруулж байх нь зүйтэй. Тухайлбал, зөвлөмжийн заалтуудын хоорондын утга санааны давхардал, бүлэг хоорондын шилжсэн утга санааг цэгцэлж, зааг ялгааг нь тодорхой гаргах. Мөн зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг одоогийн шалгуур үзүүлэлтүүдээр хангах боломжтой эсэх, шаардлагагүйг хасах, шинэ зүйл заалт нэмж оруулах, уг зөвлөмжийг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг олон нийт, төрийн байгууллагуудад тайлбарлан таниулах хэрэгтэй.
- Нэг чиг үүрэг бүхий анхан, дунд, дээд шатны байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайтар хангаж өгвөл зөвлөмжийн зарим заалтууд богино хугацаанд хэрэгжих боломжтой юм. Тухайлбал, вэб сайтын асуудлыг ийм замаар шийдэж болно.
- Байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргийн онцлогоос хамааран чиглэл чиглэлээр ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг багасгахад чиглэсэн менежментийн өөрчлөлт хийж болохуйц тусгай зөвлөмжүүдийг боловсруулан хүргүүлбэл зохино.

7.2.2 Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж хүнд суртлыг халахад олон нийтийн зүгээс тавих хяналтыг бий болгож түүний дагуу арга хэмжээ авдаг тогтолцоо бий болгох нь нэн чухал. Энэ нь 19-77 утсанд иргэд хэрхэн идэвхтэй хандаж байснаас харагдаж байна. Ялангуяа үйл ажиллагаандаа хөдөө орон нутгийн иргэдийн оролцох боломжийг бүрдүүлбэл илүү үр дүнд хүрэх болно.
- АТГ нь иргэдийн санал, гомдлыг хүлээн авахаас гадна, цаашид үйл ажиллагаандаа тэдний оролцох боломжийг бүрдүүлж өгөх нь АТГ-т итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулж, улмаар хамрах хүрээг нь өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

7.2.3 Бусад

- АТГ нь дээрхээс гадна бусад олон хэлбэрээр олон нийт болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй. ы

Найм. Ашигласан материалын жагсаалт

Судалгааны материал

1. Нээлттэй Нийгэм Форум, ARTICLE 19, Глоб Интернэшнл “МОНГОЛ УЛС ШИЛЖИЛТИЙН ҮЕД: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ” Улаанбаатар хот 2003 он
2. “АНУ”-ийн элчин сайдын яам, Глоб Интернэшнл “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” Улаанбаатар хот 2006 он
3. ЮНЕСКО “Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөв байдал” Улаанбаатар хот 2007 он
4. Глоб Интернэшнл “Мэдэх эрх, Мэдээллийн эрх чөлөө” Улаанбаатар хот 2003 он
5. Нээлттэй Нийгэм Форум “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялаг хуваарилалт” Улаанбаатар хот 2006 он
6. Зориг сан, Нээлттэй Нийгэм Форум “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан” Улаанбаатар хот 2006 он
7. Нээлттэй Нийгэм Форум, Глоб Интернэшнл “Төрөөс мэдээлэл хэрхэн олж авах вэ” Улаанбаатар хот 2007 он

Хууль, тогтоомж

1. Авлигын эсрэг хууль
2. Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх тухай
3. Аудитын тухай хууль
4. Ашигт малтмалын тухай хууль
5. Аялал жуулчлалын тухай хууль
6. Ард нийтийн санал асуулгын тухай хууль
7. Байгууллагын нууцын тухай хууль
8. Даатгалын тухай хууль
9. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль
10. Иргэний бүртгэлийн тухай хууль
11. Иргэний хууль

12. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
13. Монгол улсын засаг захиргаа түүний удирдлагын тухай хууль
14. Монгол улсын татварын ерөнхий хууль
15. Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль
16. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
17. Монгол улсын Үндсэн хууль
18. Нийгмийн даатгалын сангийн тухай хууль
19. Прокурорын байгууллагын тухай хууль
20. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль
21. Төрийн албаны тухай хууль
22. Төрийн нууцын тухай хууль
23. Төрийн нууцыг батлах тухай хууль
24. Шүүх байгууллагын тухай хууль
25. Шүүхийн тухай хууль
26. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
27. Эрүүл мэндийн тухай хууль

Байгууллагуудын тараах материал

1. БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
2. ХУД-ийн эрүү мэндийн нэгдэл
3. ХУД-ийн замын цагдаагийн тасаг
4. СБД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
5. ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
6. СБД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
7. СБД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
8. ХУД-ийн татварын хэлтэс
9. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төв
10. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
11. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
12. БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
13. ЧД-ийн засаг даргын тамгын газар
14. ХУД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
15. Нийслэлийн нийгмийн даатгалын газар
16. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар
17. Үндэсний татварын ерөнхий газар
18. ЧД-ийн татварын хэлтэс
19. ЧД-ийн газрын алба
20. СБД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
21. СБД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
22. ХУД-ийн газрын алба
23. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
24. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
25. ЧД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
26. ЧД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
27. СХД-ийн нийгмийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
28. УК-3-р эмнэлэг
29. Нийслэлийн шүүх
30. ЧД-ийн цагдаагийн хэлтэс

31. СХД-ийн цагдаагийн хэлтэс
32. Замын цагдаагийн ерөнхий газар
33. Хот байгуулалт зураг төслийн хүрээлэн
34. БЗД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
35. ЧД-ийн эрүүл мэндийн нэгдэл
36. Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
37. Иргэний бүртгэл мэдээллийн төв

Байгууллагуудын вэб сайт

- | | |
|--|--|
| 28. www.ulaanbaatar.mn | 37. www.gazar.gov.mn |
| 29. www.trafficpolice.mn | 38. www.Gpo.mn |
| 30. www.shd.ub.gov.mn | 39. www.courtservice.mn |
| 31. www.shastinhospital.mn | 40. www.chingeltei.com |
| 32. www.open-government.mn | 41. www.chemd.mn |
| 33. www.ndaatgal.mn | 42. www.chd.ub.gov.mn |
| 34. www.mta.mn | 43. www.pmis.gov.mn |
| 35. www.LSVS-D68.com | 44. www.google.mn |
| 36. www.labour.mn | 45. www.legalinfo.mn |

Ес. Хавсралт

9. 1. Авлигатай Тэмцэх Газрын зөвлөмж

Мэдээлэл хүртээмжтэй байх талаар

1. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах
2. Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих
3. Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах
4. Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн самбарт болон вэб сайтад байрлуулах
5. Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох
6. Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх
7. Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан зогсоох
8. Байгууллагын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогийн мэдүүлэг гэх мэт/-ийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох
9. Иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтаар тавих, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх

Үйл ажиллагаагаа нээлттэй байлгах талаар

10. Үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах
11. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн хариуг өгөх
12. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаархи мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй болгох
13. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүр тайлан гаргаж дүгнэж байх

Үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлэх талаар

14. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх
15. Иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, эсхүл санал хүсэлтийн хайрцаг /дэвтэр/-ыг байгууллагад байрлуулан иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах
16. Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох
17. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, тэдгээртэй танилцах боломжоор хангах
18. Байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийг улам боловсронгуй болгож, тэр дундаа ямар ёс зүйг ажилтнууд сахих талаархи заалтуудыг иргэдэд нээлттэй болгох

9.2. Судалгаанд хамруулсан байгууллагуудын нэрс

1. Яамд

- 1) Сангийн яам
- 2) Гадаад хэргийн яам
- 3) Хууль зүй, Дотоод хэргийн яам
- 4) Нийгэм хамгаалал, Хөдөлмөрийн яам
- 5) Барилга, Хот байгуулалтын яам
- 6) Байгаль орчны яам
- 7) Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
- 8) Хүнс, Хөдөө аж ахуйн яам
- 9) Эрүүл мэндийн яам
- 10) Зам тээвэр, Аялал жуулчлалын яам
- 11) Түлш, Эрчим хүчний яам
- 12) Үйлдвэр, Худалдааны яам

2. Шүүхийн шийдвэр биелүүлэх

- 13) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- 14) Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 15) БГД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 16) БЗД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 17) ЧД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 18) СБД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 19) СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба
- 20) ХУД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба

3. Засаг даргын тамгын газар

- 21) Нийслэлийн засаг даргын тамгын газар

- 22) БГД-ийн засаг даргын тамгын газар
- 23) БЗД-ийн засаг даргын тамгын газар
- 24) ЧД-ийн засаг даргын тамгын газар
- 25) СБД-ийн засаг даргын тамгын газар
- 26) СХД-ийн засаг даргын тамгын газар
- 27) ХУД-ийн засаг даргын тамгын газар

4. Татвар

- 28) Үндэсний татварын ерөнхий газар
- 29) Нийслэлийн татварын хэлтэс
- 30) БГД-ийн татварын хэлтэс
- 31) БЗД-ийн татварын хэлтэс
- 32) ЧД-ийн татварын хэлтэс
- 33) СБД-ийн татварын хэлтэс
- 34) СХД-ийн татварын хэлтэс
- 35) ХУД-ийн татварын хэлтэс

5. Нийгмийн даатгал

- 36) Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
- 37) Нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс
- 38) БГД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
- 39) БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
- 40) ЧД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
- 41) СБД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
- 42) СХД-ийн нийгмийн даатгалын хэлтэс
- 43) ХУД-ийн нийгмийн даатгалын хэлтэс

6. Цагдаа

- 44) Улсын цагдаагийн ерөнхий газар
- 45) Улсын мөрдөн байцаах ерөнхий газар
- 46) Эрүүгийн цагдаагийн газар
- 47) ЦЕГ-ийн Хэрэг бүртгэх газар
- 48) ЦЕГ-ийн нийгмийн хэв журам хамгаалах газар
- 49) БГД-ийн цагдаагийн хэлтэс
- 50) БЗД-ийн цагдаагийн хэлтэс
- 51) ЧД-ийн цагдаагийн хэлтэс
- 52) СБД-ийн цагдаагийн хэлтэс
- 53) СХД-ийн цагдаагийн хэлтэс
- 54) ХУД-ийн цагдаагийн хэлтэс

7. Хөдөлмөр, Халамж үйлчилгээ

- 55) Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар
- 56) Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 57) БГД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 58) БЗД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 59) ЧД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 60) СБД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 61) СХД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба
- 62) ХУД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний алба

8. Прокурор

- 63) Улсын прокурорын ерөнхий газар
- 64) Нийслэлийн прокурорын газар
- 65) БГД-ийн прокурорын газар

- 66) БЗД-ийн прокурорын газар
- 67) ЧД-ийн прокурорын газар
- 68) СБД-ийн прокурорын газар
- 69) СХД-ийн прокурорын газар
- 70) ХУД-ийн прокурорын газар

9. Замын цагдаа

- 71) Замын цагдаагийн газар
- 72) БГД-ийн замын цагдаагийн тасаг
- 73) БЗД-ийн замын цагдаагийн тасаг
- 74) ЧД-ийн замын цагдаагийн тасаг
- 75) СБД-ийн замын цагдаагийн тасаг
- 76) СХД-ийн замын цагдаагийн тасаг
- 77) ХУД-ийн замын цагдаагийн тасаг

10. Эмнэлэг

- 78) Эх, нялхас эрдэм шинжилгээний төв
- 79) Гэмтэл согог сэргээн засварлах үндэсний төв
- 80) Халдварт өвчин судлалын төв
- 81) Хавдар судлалын төв
- 82) УК-1-р эмнэлэг
- 83) УК-2-р эмнэлэг
- 84) УК-3-р эмнэлэг
- 85) 1-р төрөх газар
- 86) 2-р төрөх газар
- 87) БГД-ийн эрүүл мэндийн нэгдэл
- 88) БЗД-ийн эрүүл мэндийн нэгдэл
- 89) ЧД-ийн эрүүл мэндийн нэгдэл
- 90) СБД-ийн эрүүл мэндийн нэгдэл
- 91) СХД-ийн эрүүл мэндийн нэгдэл
- 92) ХУД-ийн эрүүл мэндийн нэгдэл

11. Газрын алба

- 93) Нийслэлийн газрын алба
- 94) БГД-ийн газрын алба
- 95) БЗД-ийн газрын алба
- 96) ЧД-ийн газрын алба
- 97) СБД-ийн газрын алба
- 98) СХД-ийн газрын алба
- 99) ХУД-ийн газрын алба

12. Шүүх

- 100) Улсын дээд шүүх
- 101) Нийслэлийн шүүх
- 102) БГД-ийн шүүх
- 103) БЗД-ийн шүүх
- 104) ЧД-ийн шүүх
- 105) СБД-ийн шүүх
- 106) СХД-ийн шүүх
- 107) ХУД-ийн шүүх

13. Агентлаг

- 108) Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
- 109) Иргэний бүртгэл мэдээллийн төв

- 110) Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газар
- 111) Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
- 112) Хот байгуулалт зураг төслийн хүрээлэн
- 113) Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газар
- 114) Нийслэлийн боловсролын газар
- 115) Улсын гаалийн ерөнхий газар
- 116) Нийслэлийн гаалийн газар
- 117) Үндэсний аудитын газар
- 118) Оюуны өмчийн газар
- 119) Нийслэлийн онцгой байдлын газар
- 120) Санхүүгийн зохицуулах хороо
- 121) Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар
- 122) Төрийн өмчийн хороо
- 123) Гадаадын хөрнгө оруулалтын газар
- 124) Иргэний нисэхийн ерөнхий газар

9.3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, эрх хэмжээ

Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн /Монгол Улсын Үндсэн хууль, 1.2-р зүйл/	
ТӨРИЙН АЛБА	
Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ. Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.	
Төрийн албаны зарчим	<ul style="list-style-type: none"> • Захирах, захирагдах ёс; ил тод байх; ард түмэнд үйлчлэх; иргэд хуульд заасан болзол, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх; төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;
Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; • Өргөсөн тангарагтаа үнэнч байх; • Эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах; • Төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх; • Албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

“Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторинг

	<ul style="list-style-type: none"> Төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх
Төрийн жинхэнэ албан хаагчийн хориглох үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бусад хангамж эдлэх; Хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авах;
ЗАСГИЙН ГАЗАР	
Засгийн газар нь Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> Асуудлыг хамтран хэлэлцэж олонхийн санаа бодолд түшиглэн цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж шийдвэрлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг дангаар хариуцах, үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээх, нутаг дэвсгэрийн болон салбарын зарчмыг хослуулах үндсэн дээр ажиллана
Нийтлэг чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах <ul style="list-style-type: none"> Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах; Төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх; Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
ЯАМ	
Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн	
Үйл ажиллагааны үндсэн зарчим	<ul style="list-style-type: none"> Төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай, соёлч байдлыг хангах, мэргэшсэн байх, ил тод нээлттэй байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, яамд нь бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцон харилцан хүндэтгэх
Яамны нийтлэг эрхлэх асуудал	<ul style="list-style-type: none"> Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; Хүний эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;
Иргэдтэй харьцах	<ul style="list-style-type: none"> Иргэдээс сайдын эрхлэх хүрээний асуудлаар гаргасан санал, өргөдөл, гомдлыг хуульд заасан журмын дагуу хүлээн авч хянан шийдвэрлэнэ. Яам нь сайдаас иргэдийг хүлээн авч уулзах ажлыг сард 2-оос доошгүй удаа зохион байгуулна.
Мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> Сайдын тушаал, яамны бодлого, үйл ажиллагааны талаар нийтэд албан ёсоор мэдээлж байх зорилгоор эмхтгэл гаргаж болно.
АГЕНТЛАГ	
Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. Тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлаг байна.	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> Төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.
Нийтлэг эрхлэх асуудал	<ul style="list-style-type: none"> Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах; Хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;

	<ul style="list-style-type: none"> • Хуулиар эрх олгосон бол нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журам, норм, нормативыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;
Мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> • Агентлагийн даргын тушаал, үйл ажиллагааныхаа талаар албан ёсоор нийтэд мэдээлэх зорилгоор агентлаг нь эмхтгэл гаргаж болно.
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР	
Нийслэлийн засаг даргын тамгын газрын удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим	<ul style="list-style-type: none"> • Нийслэлийн удирдлагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ оршин суугчдынхаа хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ. • Иргэдийн санал бодол, нутаг дэвсгэртээ ажиллаж буй төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, сүм хийд, буяны болон сайн санааны байгууллага, олон түмний идэвх оролцоонд тулгуурлах зарчмыг баримтална.
Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах; • Сум, дүүргийн Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих; • Иргэдийг хүлээж авах ажлыг зохион байгуулж, тэднээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх; • Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах; • Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх, хяналт тавих; • Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;
Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Төр, засгийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; • Хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад орон нутгийн нөөц бололцоог илрүүлж ашиглах ажлыг зохион байгуулах, энэ талаар иргэдээс гаргасан санаачлагыг дэмжих; • Хүн амын боловсролын түвшинг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах; • Шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; • Нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судлах; • Хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах; • Хүн ам, түүний шилжилт хөдөлгөөнийг зохих журмын дагуу бүртгэх; • Захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачлагыг нь дэмжих; • Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;
ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, АЛБАД	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Хууль дээдлэх ёсны эрх ашгийг хүндэтгэх зарчим
Үндэсний татварын ерөнхий газарүндсэн чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; • Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал гаргах, сургалт, сурталчилгаа явуулах; • Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.
Татварын улсын ерөнхий байцаагчийн бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Татварын албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангах;

	<ul style="list-style-type: none"> • Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлал, зөвлөмж гаргах; • Татварын улсын байгцаагчийн гаргасан актыг хуулийн дагуу хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгох; • Татварын улсын байцаагч, татварын улсын ахлах байцаагч бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХЭЛТЭС	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын байгууллага өөрийгөө санхүүжүүлэх, нийгмийн даатгалын байцаагч хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах зарчим баримтална.
Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах; • Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах; • Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг Тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах; • Доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС	
Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; • Халамжийн сан бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах; • Халамжийн сангаас тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах; • Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг сурталчлах; • Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, АЛБАД	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт	<ul style="list-style-type: none"> • Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын дарга, захирагч нар тухайн байгууллагын алба хаагчдын өдөр тутмын ажилд дотоодын хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авна.
Цагдаагийн ерөнхий газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх; • Цагдаагийн байгууллагын ажлыг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, харьяа албад, орон нутгийн цагдаагийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах; • Цагдаагийн байгууллагыг зэвсэг техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад материалаар хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх; • Цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн явуулах ажлыг зохион байгуулах;
Гомдол хянан шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> • Хойшлуушгүй ажиллагааг хууль бусаар хийсэн гэж үзэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага прокурор буюу цагдаагийн дээд шатны байгууллагын даргад гомдол гаргах эрхтэй. Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж, хариу өгнө.
ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР	

“Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторинг

Замын цагдаагийн газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих; Хууль, замын хөдөлгөөний дүрмийг сурталчлах, осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиох; Тээврийн хэрэгслийн улсын дугаар олгох; Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авч, жолоодох эрхийн үнэмлэх олгох;
УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> Хууль дээдлэх, иргэний хуулиар олгогдсон халдашгүй эрхийг хүндэтгэх, доод шатны гаалийн байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах зарчмыг удирдлага болгоно.
Гаалийн байгууллагын үндсэн үүрэг	<ul style="list-style-type: none"> Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих; Гаалийн болон бусад татварыг ногдуулж, барагдуулах; Гаалийн статистикийн мэдээлэл гаргах; Гаалийн хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх.
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР	
<p>Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагдана. Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.</p>	
Төрийн аудитын зарчим	<ul style="list-style-type: none"> Хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байна.
Үндэсний аудитын газрын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> Төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан уг асуудлыг зохих журмын дагуу хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Үндэсний аудитын газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэнэ;
Мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> Хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудитын болон бусад тайланг хэвлэн нийтлэх буюу бусад арга замаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээж болно Төрийн аудитын байгууллага өөрийн хийсэн аудитын тайлангийн жагсаалтыг улирал тутам гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим сүлжээгээр мэдээлнэ. Төрийн аудитын байгууллага хүсэлт ирүүлсэн хүмүүст төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хэвлэмэл эхээр нь буюу хувилж өгнө. Төрийн аудитын байгууллага аудитын тайланг хэвлэн нийтлэх, хувилж олшруулахад зарцуулсан зардлыг нөхөх зорилгоор төлбөр авч болно.
ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР	
<p>Нууцын зэрэглэлтэй материал үйлдвэрлэж, хадгалж байдгийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн тусгай хамгаалалтад байна.</p>	
Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх Нууцын зэрэглэлтэй зургийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бүрэн бүтэн байдлыг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хянан шалгах; Төрөл бүрийн масштабтай байр зүйн болон дэвсгэр зургийг олгох, худалдах, шилжүүлэх, мэдээллээр хангах.
Геодези, зураг зүйн газрын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

	<ul style="list-style-type: none"> • Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох • Геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөл олгох; • Газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих.
НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБА	
Нийслэлийн газрын албаны эрх хэмжээ	<ul style="list-style-type: none"> • Газрын кадастр эрхлэх, аймаг, нийслэлийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх; • Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох; • Газрын мэдээллийн улсын санг бүрдүүлэх, хөтлөх, нийтэд үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах; • Газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний талаархи тайланг Засгийн газарт жил бүр гаргаж, энэ талаархи мэдээллээр нийтэд үйлчлэх;
Дүүргийн газрын албаны эрх хэмжээ	<ul style="list-style-type: none"> • Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох; • Эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх;
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР	
Байгууллагын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Нууцын зэрэглэлд хамруулснаас бусад геологи, уул уурхайн мэдээлэл, энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өгсөн мэдээллийг сонирхсон этгээдэд хүргэх; • Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих; • Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих; • Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх; • Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох; • Сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх.
Мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> • Тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
Гомдол гаргах	<ul style="list-style-type: none"> • Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.
ИРГЭНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтална.
Иргэний бүртгэл, мэдээллийн улсын	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээг олгох, хүчингүй болгохтой холбогдсон

төвийн чиг үүрэг	<p>бодлого хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын иргэний бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, цахим тоолуурт хадгалах ажлыг зохион байгуулах; • Иргэний бүртгэлтэй холбогдсон мэдээлэл, лавлагаагаар иргэд, байгууллагад хүсэлтийнх нь дагуу үйлчлэх; • Төв, орон нутгийн бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь хянан шалгах;
ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН УЛСЫН ТӨВ	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байх; • Бүртгэл үнэн зөв байх; • Бүртгэл нэгдсэн байх.
Эрхийн улсын бүртгэлийн байгууллагын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус эрхийг бүртгүүлэх тухай мэдүүлгийг хүлээн авч хянан үзэх, эрх зүйн дүгнэлт өгөх, зохих шийдвэр гаргах; • Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлийн дугаар олгон бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгох; • Эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд энэ хуульд заасны дагуу гаргаж өгөх; • Шүүх, эрх бүхий бусад байгууллагад зохих журмын дагуу лавлагаа гаргаж өгөх; • Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус эрхийн талаар шүүх, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх
Эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байх	<ul style="list-style-type: none"> • Эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байна. • Иргэн, хуулийн этгээдэд эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээллийг мэдээлэл авах тухай бичгээр гаргасан хүсэлт, иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн төлөөлөгчид бичгээр олгосон итгэмжлэлийг үндэслэн зохих төлбөртэйгээр гаргаж өгөх бөгөөд мэдээлэл авсан этгээдийн хүсэлтээр мэдээлэлд дурдсан зүйлд холбогдох хэсгийг зохих төлбөртэйгээр хуулбарлан өгч болно • Гаргаж өгөх мэдээлэл нь өмчлөгчийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа газар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, байршлын талаархи мэдээллийг агуулсан байна. • Өмчлөгч нь бичгээр зөвшөөрсөн бол дэлгэрэнгүй мэдээллийг өгч болно. • Эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн барьцааны үүрэг гүйцэтгүүлэгчид тухайн барьцаатай холбогдсон мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүй өгнө • Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор мэдээлэл өгнө
УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР	
Мэргэжлийн хяналтыг хуулиар эрх олгогдсон байгууллага, алба хэрэгжүүлэх бөгөөд түүнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх
Мэргэжлийн хяналтын газрын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомж болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын биелэлтэд хяналт тавих; • Мэргэжлийн хяналтын орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; • Хяналтын хууль тогтоомж, түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрэглэж байгаа байдлыг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа зохих байгууллагад оруулах;
Мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын байгууллага хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлнэ.

Иргэдтэй харилцах	<ul style="list-style-type: none"> • Хяналт шалгалтын байгууллага өөрийн эрхлэх хүрээний асуудлаар иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж болно.
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР	
Оюуны өмчийн газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, • Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авч, хянан шийдвэрлэх; • Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загвар, зохиогчийн эрх, хамаарах бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох; • Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухай мэдээллийг хэвлэн нийтлэх; • Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа гаргаж өгөх; • Патентийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх; • Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн бүтээлийн үнэлгээг зохиогчийн хүсэлтээр баталгаажуулах; • Ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах • Хуулиар харьяалуулсан маргааныг хянан шийдвэрлэх.
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг цаг хугацаанд нь явуулах; • Гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүн ам, үйлдвэрлэлийн нягтрал, байршил, байгаль, цаг уурын нөхцөл, үйлдвэрлэл, технологийн онцлог, гамшгийн бодит аюулын хэр хэмжээг харгалзан үзэх; • Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээг иж бүрнээр хэрэгжүүлэх;
Чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Онцгой байдлын газар нь гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.
Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> • Онцгой байдлын газар болон гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагаа, гамшиг, түүний аюул, хор уршиг, үр дагаврын тухай мэдээлэл нь хуульд өөрөөр заагаагүй бол нийтэд нээлттэй, ил тод байна. • Онцгой байдлын газар болон гамшгаас хамгаалах алба гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн тухай хүн амд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр цаг тухайд нь үнэн зөв мэдээлнэ. • Гамшгаас хамгаалах тухай мэдээлэл, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх;
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Бие даасан, ил тод байх, бусдын нөлөөнд үл автах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах
Хорооны бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах • Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих; • Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах

	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих; • тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг шалгах; • тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх; • Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих.
ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ГАЗАР	
Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, • Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, • Өрсөлдөөнд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гаргах,
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО	
Төрийн өмчийн хороо нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн байгууллага мөн.	
Төрийн өмчийн хорооны бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах; • Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах; • Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах; • Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих;
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР	
Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх нэгдсэн зорилттой уялдуулан боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих; • Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих; • Гадаадын хөрөнгө оруулалтын талаархи бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; • Гадаадын хөрөнгө оруулагчдад “нэг цэг”-ийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх; • Гадаадын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах;
ПРОКУРОР	
Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх
Прокурорын байгууллагын	<ul style="list-style-type: none"> • Прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил, ял эдлүүлэх шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хяналт тавих • Захиргааны эрх бүхий байгууллагад ирсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянах; • Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгаж шийдвэрлэх, эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянах;

	<ul style="list-style-type: none"> • Прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно. • Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно.
Прокурорын ёс зүй	<ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчийн болон прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахих;
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ГАЗАР	
Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн. Иргэний нисэхийн ерөнхий газар үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулахад чиглүүлнэ.	
Иргэний нисэхийн газрын бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Иргэний нисэхэд хамаарах асуудлыг зохицуулан удирдах, салбарын хөгжлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх; • Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авах • Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг батлах • Иргэний нисэхийн салбарт холбогдох мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар бусад этгээдтэй хамтран ажиллах;
УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХ	
Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн. Шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн.	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. • Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.
Улсын дээд шүүхийн бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх; • Хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх; • Хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх; • Үндсэн хуулиас бусад хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах; • Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх;
Аймаг, нийслэлийн шүүхийн бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх; • Суулиар харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх; • Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах;
Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн бүрэн эрх	<ul style="list-style-type: none"> • Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, дагнасан шүүхэд хуулиар тусгайлан харьяалуулснаас бусад хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;
Захиргааны хэргийн шүүх	<ul style="list-style-type: none"> • Хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;
Шүүгчийн ёс зүйн дүрэм	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын шүүхийн шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. • Шүүгчийн ёс зүйн дүрмийг Шүүгчдийн зөвлөл батална.

	<ul style="list-style-type: none"> • Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ.
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн.	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх
Ерөнхий газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
Шийдвэр гүйцэтгэх газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих • Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх; • Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх; • Согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх.
Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, түүнчлэн эрүүгийн хэргийн талаар гарсан торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих; • Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял, түүнчлэн албадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих; • Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын арбитрын байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих; • Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг явуулах; • Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон шийдвэр гүйцэтгэгчийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх.
Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүгчийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнчлэн баривчлах, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах; • Хорих байгууллагыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР	
Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ.	
Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> • Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана; • Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана
Чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах; • Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, аттестатчилах; • Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА	
Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг	<ul style="list-style-type: none">• Байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгөх;• Эрүүл мэндийн хууль тогтоомжийг бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд сурталчлан таниулах;• Үйл ажиллагааныхаа тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж өгөх, бусад байгууллага, иргэнийг эрүүл мэндийн асуудлаар өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

*/*НОМЫН ХАВТСАНД ОРУУЛАХ*/*

Мониторингийн баг:

- | | |
|-------------------|-------------------------------------|
| 1. Х.Наранжаргал | <i>Төслийн зөвлөх</i> |
| 2. Д.Мөнхбүрэн | <i>Төслийн зөвлөх</i> |
| 3. Ж.Мөнхсайхан | <i>Төслийн зохицуулагч</i> |
| 4. Г.Цогтбаатар | <i>Төслийн зөвлөх судлаач</i> |
| 5. З.Зоригтсайхан | <i>Төслийн ахлах судлаач</i> |
| 6. Г.Насанбат | <i>Мэдээлэл оруулагч, кодлогч</i> |
| 7. Л.Цэвэлсүрэн | <i>Утасны мэдээлэл хүлээн авагч</i> |

Мэдээлэл бүрдүүлсэн мониторингчид:
Мониторингийн 1 дүгээр шатанд

1. М.Амартүвшин
2. Б.Буянжаргал
3. Ц.Оюунбилэг
4. Д.Батбаяр
5. Б.Уртнасан
6. Г.Батдорж
7. Б.Бат-Эрдэнэ
8. П.Энэбиш
9. Д.Ядамжав
10. Б.Эрдэнэбат
11. Б.Цэрэндолгор

Мониторингийн 2 дугаар шатанд

1. Ц.Даваасүрэн
2. Г.Батдорж
3. Б.Уртнасан
4. Ц.Оюунбилэг
5. Ч.Энхбаяр
6. М.Амартүвшин
7. Г.Мөнхбат
8. Б.Бат-Эрдэнэ
9. П.Энэбиш